МОНГОЛБАНК

ИНФЛЯЦЫН ТАЙЛАН

2023

3-Р САР

АГУУЛГА

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ 3
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР 4
ТОЙМ 5
1. ИНФЛЯЦ 7
1.1. Инфляцын цаашдын төлөв 7
1.2. Инфляцын гүйцэтгэл 9
1.3. Төсөөллийн зөрүү 10
2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ 11
2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв 11
2.2. Потенциал үйлдвэрлэл 14
2.3. Үйлдвэрлэлийн зөрүү 14
2.4. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл 15
3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН 17
3.1. Хөдөлмөрийн зах зээл 17
3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл 19
3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд 19
3.2.2. Хүү 23
3.2.3. Валютын ханш 24
3.2.4. Хөрөнгийн зах зээл 25
3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр 28
4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН 30
4.1. Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл 30
4.2. Экспортын үнийн төлөв 32
4.3. Төлбөрийн тэнцэл 33
ЗУРГИЙН ЖАГСААЛТ 36
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 37

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк **инфляцыг 2023-2024 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах**ыг зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ, өртгийн хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүгийн өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц болон тэдгээрийн ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлдөг. Ингэхдээ бодлогын хэрэгсэл нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн бодлогын хүүгийн коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогдож байна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 3-р сарын 14, 15-ны өдрийн ээлжит хурлаар:

1. Бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах;
2. Бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгох;
3. Банкны гадаадын зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр шинээр татсан 360 хоног хүртэлх хугацаатай эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох шийдвэр гаргалаа.

Мөнгөний бодлогын 2023 оны 3-р сарын 15-ны өдрийн мэдэгдлийн дэлгэрэнгүйг эндээс уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг дараах линкээр орж татан авах боломжтой.

© Монголбанк 2023

ТОЙМ

Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Гадаад харилцааны нөхцөл байдал өөрчлөгдөх, бүс нутагт шинэ нөхцөл байдал үүсэх, үүссэн нөхцөл байдал гүнзгийрэх зэрэг нь тааварлах боломжгүй тодорхой бус байдлын эх сурвалж болж байна. Түүнчлэн, ОХУ-Украины нөхцөл байдал цаашид даамжрах, дэлхийн төв банкуудын мөнгөний хатуу бодлогын нөлөө глобал эдийн засагт хүчтэй илрэх нь дэлхийн эдийн засгийн төсөөлөлд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс юм. Харин глобал эдийн засагт инфляцын эрч саарч, инфляцын хүлээлт тогтворжиж байгаатай холбоотойгоор дэлхийн томоохон төв банкууд бодлогын хүүгээ эрчтэй нэмэгдүүлэхээ сааруулж байгаа нь төсөөлөлд эергээр нөлөөлж байна. Манай улсын гадаад эрэлтийг голлон тодорхойлогч БНХАУ-д “Тэг-Ковид” бодлогын хязгаарлалт суларсантай холбоотойгоор экспортын гол нэрийн барааны үнэ болон уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв сайжирлаа. Нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн нөлөө алгуур багасахын зэрэгцээ шатахууны үнийн төсөөлөл буурснаар инфляцын төсөөллийг өмнөхөөс бууруулав. Ийнхүү инфляц цаашид алгуур саарах хүлээлттэй байгаа хэдий ч валютын ханш, эрэлтийн хүчин зүйлсийн нөлөө нэмэгдэж болзошгүй байна.

Инфляцын төсөөлөл өмнөх төсөөлөлтэй харьцуулахад буурлаа. Инфляц 2023 оны 2 дугаар сард улс болон Улаанбаатар хотод 12.1 хувьд хүрсэн нь өмнөх оны IV улирлаас 2.9 хувь буурсан үзүүлэлт юм. Ийнхүү сүүлийн саруудад инфляц өмнөх төсөөлөлтэй нийцтэйгээр алгуур саарахад импортын барааны тээврийн зардал буурсан нь голлон нөлөөллөө. БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогын хязгаарлалт суларч ачаа, тээврийн урсгал сайжирч, зардал буурснаар импортын барааны үнийн өсөлт саарах, АИ-92 шатахуун авах гэрээний үнэ тогтвортой байх, дизель түлшний онцгой албан татварыг чөлөөлсөн зэрэг хүчин зүйлс нь инфляцын төсөөллийг өмнөхөөс бууруулахад голлон нөлөөлөв. Гэхдээ эрэлтийн болон ханшийн нөлөөгөөр инфляц энэ суурь төсөөллөөс илүү алгуур буурах буюу харьцангуй өндөр түвшинд хадгалагдах эрсдэл байсаар байна.

Өмнөх төсөөлөлтэй харьцуулахад 2023 оны эдийн засгийн өсөлтийн төлөвийг сайжрууллаа. Эдийн засгийн өмнөх оны 4 дүгээр улиралд хүлээлтээс давж 7.3 хувиар тэлснээр жилийн өсөлт 2022 онд 4.8 хувиар өслөө. Эдийн засгийн идэвхжил хүлээлтээс өндөр байхад хилийн хязгаарлалт суларч тээвэрлэлт сэргэсэнтэй холбоотойгоор нүүрс, зэсийн баяжмалын олборлолт нэмэгдсэн бол уул уурхайн бус салбарын хувьд эрчим хүч, худалдааны салбараас бусад салбарын үйлдвэрлэл хүлээлтээс давсан нь голлон нөлөөлөв. Уул уурхайн салбарын төсөөлөл нэмэгдсэнээр энэ оны эдийн засгийн өсөлтийн төлөвийг сайжруулав. Тодруулбал, нүүрс, төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэх, зэсийн баяжмалын алтны агууламжийн таамаглал өмнөх төсөөллөөс нэмэгдэв. Уул уурхайн бус салбарын хувьд нүүрсний экспортыг дагаад авто замын тээвэр нэмэгдэх, дамжин өнгөрөх ачаа тээвэр хэвийн түвшинд хүрч сэргэснээр тээврийн салбар эрчимжихээр байна. Түүнчлэн энэ онд том малын тоо өсөж байгаа нь хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэхэд нөлөөллөө. Харин мэдээлэл холбоо, эрчим хүчний салбарын саарах хандлага үргэлжилж, өрхийн хэрэглээний өсөлт удааширснаар худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар зэрэг салбарын өсөлт саарах төлөвтэй байна.

Нэгдсэн төсвийн 2023 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн тэнцэл 23 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлогын гүйцэтгэл эдийн засгийн идэвхжилийг даган сайн байж 2022 оны эцэст төсвийн алдагдал хүлээж байснаас бага, 1 их наяд төгрөг буюу ДНБ-ний 2.1 хувь хүрэв. Төсвийн орлого 2023 оны эхний 2 дугаар сард 100.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар нэмэгдэж 2.8 их наяд төгрөг байв. Харин төсвийн нийт зардал энэ оны эхний 2 сард 2.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар өсөв.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт бага зэрэг сэргэж, банкны системийн нийт зээлийн өсөлт бага түвшинд ч гэсэн тогтвортой байна. М2 мөнгөний өсөлт сүүлийн саруудад эрчимжихэд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын цэвэр орох урсгал нэмэгдсэн нь голлон нөлөөлж байна. Түүнчлэн, банкны системийн зээлийн өсөлт 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн эрчимтэй буурч байсан бол сүүлийн сард тогтворжиж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эерэг нөлөөтэй байна. Цаашид төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотой банкны зээл олгох боломжтой төгрөгийн эх үүсвэр төдийлөн нэмэгдэхгүй, банкууд зээлийн шалгуур болон нөхцөлөө 2022 оны сүүлийн хагаст чангаруулсан зэрэг нь зээлийн нийлүүлэлтийг хязгаарлахаар байна. Банкны системийн эх үүсвэр талаас гадаад валютын харилцах, хадгаламж мөнгөний нийлүүлэлтийг голлон бүрдүүлж, эх үүсвэрийн долларжилт үргэлжлэн нэмэгдэж байна. Зээлийн өсөлтийг хэрэглээний зээлийн өсөлт бүрдүүлж байгаа бөгөөд бизнесийн зээлийн өсөлт сарааад үргэлжлэн сарааад байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарч, өмнөх төсөөллийн орчимд байна. Нэг талаас БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын хязгаарлалтын арга хэмжээ 2022 оны сүүлээс суларсан, олон улсад инфляцын эрч саарч буйтай холбоотойгоор дэлхийн томоохон төв банкууд бодлогын хүүгээ эрчтэй нэмэгдүүлэхээ сааруулж байгаа нь төсөөлөлд эергээр нөлөөлж байна. Түүнчлэн, манай гадаад эрэлт сайжирч экспортын гол барааны үнэ өмнөх төсөөллөөс нэмэгдлээ. Нөгөө талд, шинжээчдийн дүгнэлтээр ОХУ-Украины нөхцөл байдал цаашид даамжрах, дэлхийн төв банкуудын хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын нөлөө глобал эдийн засагт 2023 онд хүчтэй илрэх, нийлүүлэлтийн сүлжээний доголдол бүрэн арилаагүй байгаа зэрэг нь дэлхийн эдийн засгийн төсөөлөлд сөргөөр нөлөөлөх голлох хүчин зүйлс болж байна.

Төлбөрийн тэнцэл 2022 оны 4 дүгээр улиралд 632 сая ам.долларын ашигтай гарсан ч жилийн дүнгээр 727 сая ам.долларын алдагдалтай байлаа. Нүүрсний экспортын биет хэмжээ 2022 оны сүүлийн хагаст нэмэгдэж урсгал тэнцлийн алдагдал буурсаар байгаа хэдий ч хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын хурдтай өсөлт, үйлчилгээний дансны алдагдал өндөр хэвээр хадгалагдаж байна. Санхүүгийн данс 2022 оны сүүлийн улиралд 794 сая ам.долларын ашигтай гарч оны нийт дүнгээр 2.0 тэрбум ам.долларт хүрэв.

1. ИНФЛЯЦ

1.1. Инфляцын цаашдын төлөв


Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг энэ оны эхний хагаст 13 хувьд хэвээр хадгалах
- Төрийн зохицуулалттай барааны үнэ өөрчлөгдөхгүй.
- Цаашид хилийн болон дотоодын хязгаарлалт тогтоохгүй.
- АИ-92 шатахуун авах гэрээний үнэ энэ онд өөрчлөгдөхгүй.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байна.
- Дотоодын гол нэрийн хүнсний барааны нийлүүлэлт тогтвортой байх (өргөн хүрээг хамарсан малын гоц халдварт өвчин гарахгүй г.м)
- Гадаад инфляц алгуур буурах, дэлхийн зах зээл дээр хүнсний үнэ болон тээврийн зардал өсөхгүй, алгуур буурах

Инфляц эрэлтийн бус хүчин зүйлсийн нөлөөгөөр өмнөх төсөөллөөс буурахаар байна. Хүнсний инфляцын төсөөлөл өмнөхөөс бага зэрэг нэмэгдэж, хүнсний бус инфляцын төсөөлөл буурав. Тодруулбал, мах болон махнаас бусад дотоодын хүнсний үнэ өнгөрсөн оны төгсгөлөөс эрчтэй өссөн нь хүнсний инфляц өмнөх төсөөллөөс нэмэгдэхэд нөлөөлөв. Харин хүнсний бус инфляцын төсөөлөл буурч байгаа нь дараах хүчин зүйлсээс шалтгааллаа.

- БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогын хязгаарлалт суларсантай холбоотой ачаа, тээврийн эргэлт түргэсэж, тээврийн зардал буурснаар импортын барааны үнийн өсөлт өмнө нь авч үзсэнээс илүү саарахаар байна.
- Роснефть компанитай байгуулсан гэрээ шинэчлэгдсэнтэй холбоотойгоор АИ-92 шатахууны хилийн үнэ буурч, гаалийн албан татварыг 2023 онд чөлөөлсөн, дизель түлшний онцгой албан татварыг 2023 оны 7 дугаар сарын 1 хүртэл чөлөөлсөн зэргээс үүдэн дотоодын шатахууны үнийн төсөөллийг бууруулж авч үзлээ.

Зураг 1.1 Инфляцын өмнөх болон одоогийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

Энэ онд эдийн засаг идэвхжиж, эрэлт нэмэгдэхээр байгаа боловч инфляц нийлүүлэлтийн болон зардлын шалтгаантайгаар цаашид буурах хүлээлттэй байна. Тодруулбал, глобал эдийн засагт үүсээд байсан тээвэр, логистикийн саатал буурч, гадаад үнэ тогтворжих; тээврийн зардал үргэлжлэн буурах[1] нөлөөгөөр импортын барааны инфляцад үзүүлэх шууд болон шууд бус нөлөө саарах төлөвтэй байна. Түүнчлэн дотоодын шатахууны инфляц буурахаар хүлээгдэж байна. АИ-92 шатахууны үнэ гэрээгээр зохицуулагдах бол бусад шатахууны үнэ дэлхийн зах зээлийн үнийн хандлагыг дагана гэж үзлээ. Ийнхүү энэ онд хүнсний бус инфляц алгуур буурах хандлага үргэлжлэхээр байна. Ирэх онд гадаад үнэ тогтворжсоноор, импортын бараа үйлчилгээний үнэ тогтворжиж улмаар

[1] Глобал контейнерийн индекс (ГКИ) хэвийн үед 1300-1500 хооронд хэлбэлздэг байсан ба 2020 оны төгсгөлөөс хурдтайгаар өсөж 2021 оны 9 дүгээр сард оргил түвшин болох 10839 болж хэвийн үеийнхээс 7 дахин өссөн. 2022 оны эхэнд уг индекс 9806 байсан ба 2022 оны турш буурсаар 2023 оны 2 дугаар сарын төгсгөлд 1984 болж буурсан хэдий ч хэвийн үеийнхээс бага зэрэг өндөр байна.

хүнсний бус инфляц тогтвортой байх төлөвтэй байна.

Хүнсний инфляцын хувьд энэ онд суурь үеийн нөлөө, тээврийн зардал, импортын хүнсний үнийн өсөлт саарах зэргээс үүдэн буурахаар байна. Тодруулбал, сүү, сүүн бүтээгдэхүүний үнийн өсөлт улирлын хандлагаараа энэ оны 2 дугаар улирлаас саарахаар байна. Гурил, гурилан бүтээгдэхүүний хувьд өнгөрсөн оны сүүлийн улиралд хурдацтай өссөн суурь үеийн нөлөөгөөр инфляц буурахаар хүлээгдэж байна. Импортын хүнсний инфляц дэлхийн хүнсний үнэ буурах, гадаад үнэ тогтворжих, тээврийн доголдол сайжирснаар саарах хүлээлттэй байна. Харин махны үнэ энэ оны эхний 2 сард эрчтэй өссөн бөгөөд ирэх саруудад улирлын хандлагаа даган өсөхөөр байна. Ирэх онд нийлүүлэлтийн сүлжээний доголдол арилах, үүнийг дагаад дэлхийн хүнсний үнэ буурах, гадаад үнэ тогтворжих нөлөөгөөр хүнсний инфляц үргэлжлэн буурах хүлээлттэй байна.

Инфляц энэ онд зорилтот түвшинд хүрч бууран 2024 онд зорилтот түвшний интервалд тогтворжих төсөөлөлтэй байна.

Хүснэгт 1.1 Инфляцын төсөөлөл

	2022	2023*	2024*	2025*
		төсөөлөл		
Инфляц[2]	14.0	**8.1** [6.1-10.1][3]	**7.0** [5.2-8.8]	**6.6** [5.4-7.9]

Эх сурвалж: Монголбанк

Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал:

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Төсвийн зардал энэ онд огцом тэлж байгаа, төлбөрийн тэнцлийн алдагдал үргэлжлэх, хүлээлт зэргээс үүдэн ханш сулрах дарамт нэмэгдэх тохиолдолд импортын бараа, бүтээгдэхүүн, цаашлаад дотоодын барааны үнийг өсгөх, инфляцыг нэмэгдүүлж болзошгүй.	Өндөр	Дунд (өсгөх)
БНХАУ-ын Тэг-Ковид бодлогын хязгаарлалтын арга хэмжээ суларснаар газрын тосны эрэлт нэмэгдэх, ОПЕК болон бусад газрын тос нийлүүлэгч орнууд нийлүүлэлтээ бууруулж байгаа нь дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ эргээд нэмэгдэх, цаашлаад дотоодын шатахууны үнэ нэмэгдэж, үүний дам нөлөөгөөр бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг өсгөх эрсдэлтэй.	Дунд	Дунд (өсгөх)
Геополитикийн нөхцөл байдал илүү хурцдах, улс хоорондын хязгаарлалтууд зэргээс үүдэн нийлүүлэлтийн сүлжээний доголдол даамжирвал тээврийн зардал өсөж, улмаар импортын бараа, бүтээгдэхүүний үнээр дамжин инфляцыг нэмэгдүүлж болзошгүй.	Дунд	Өндөр (Өсгөх)
Цаг агаарын нөхцөл муудах, нийлүүлэлтийн гэнэтийн шок үүсвэл мах, хүнсний ногооны үнэ өөрчлөгдөх, мөн төрийн зохицуулалттай бараа бүтээгдэхүүний үнэ төсөөллөөс өөрчлөгдөх зэрэг нь инфляцыг хэлбэлзүүлэх магадлалтай.	Дунд	Дунд

[2] ХҮИ-ээр хэмжигдэх инфляц, 4 дүгээр улирлын дундаж

[3] 30 хувийн магадлалтай итгэх интервал

Инфляцын богино хугацааны хүлээлт буурав[4].


Сүүлийн саруудад үнийн өсөлт тогтворжиж байгаатай холбоотойгоор иргэдийн инфляцын богино хугацааны хүлээлт буурч байна. 2022 оны 4 дүгээр улирлын түүвэр судалгаагаар иргэдийн инфляцын хүлээлт буурсан хэдий ч өндөр түвшинд хэвээр байна (Хүснэгт 1.2). Инфляцын чиглэлийн индекс[5] буюу иргэд инфляц өсөх, буурахыг хэрхэн хүлээж байгааг илтгэдэг уг индекс өмнөх улирлаас нилээд буурсан ч “инфляц өснө” интервалд байгаа буюу иргэд ирэх 3 сард инфляц өснө гэж хүлээсэн хэвээр байна (Зураг 1.2).

Хүснэгт 1.2 Инфляцын хүлээлт

	2023.I	2023.IV
Тоон хариулт[6]	9.8	11.3
Чанарын хариулт[7]	16.9	12.5
Мэдрэмжид суурилсан арга[8]	14.1	11.1

Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.2 Үнийн өсөлтийн талаарх хандлага (чиглэлийн индекс, 3 сар)




Эх сурвалж: Монголбанк

1.2. Инфляцын гүйцэтгэл

Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг дунд хугацаанд жилийн 6 хувийн орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилттой ажиллаж байна.

Инфляц[9] 2022 оны IV улиралд улсын хэмжээнд 14.1 хувь, Улаанбаатар хотод 14.0 хувьд хүрч өмнөх улирлаас 0.8 болон 0.9 нэгж хувиар буурав. Ийнхүү буурахад 6, 7 дугаар сард үнэ нь огцом өсөөд байсан хүнсний ногооны үнэ эргэн хямдарсан, махны үнэ өмнөх оны мөн үеэс 1.5 хувь буурсан болон тээврийн хүндрэлтэй холбоотой импортын бараа, бүтээгдэхүүний үнэ 2021 оны сүүлийн саруудад огцом өссөн суурь үе голлон нөлөөлөв.

Зураг 1.3 Инфляц



Эх сурвалж: УСХ

Инфляц 2023 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 12.2 хувь, Улаанбаатар хотод 12.1 хувьд хүрч алгуур буурах хандлага үргэлжилж байна (Зураг 1.3). Зураг 1.4, Зураг 1.5-т үзүүлсэн тайлант сарын Улаанбаатар хотын инфляцын хөдөлгөөнд

[4] Монголбанкны Судалгаа статистикийн газраас улирал бүр боловсруулдаг “Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ны тайланд үндэслэв.

[5] Өснө, буурна гэсэн хариултуудын зөрүүгээр чиглэлийн индексийг (тэнцлийн статистик) тооцно. Ингэхдээ иргэдээс ирэх 3 сард үнийн өсөлт ямар байх талаар асууж, хариултуудыг [3;-1] байхаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон.

[6] Санал асуулгад оролцсон хүмүүсээс инфляцын хүлээлтийг тоон утгаар асууж дунджилж гаргасан.

[7] Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцсон. Энэ аргачлал нь түүвэр судалгаанд оролцогчдын хариултуудыг магадлалын функц ашиглан тоон утганд хөрвүүлж, хүлээлтийг тооцдог.

[8] Түүвэр судалгаанд оролцогчдын хариултаас мэдрэгдсэн үнийн өсөлтийг одоогийн инфляцтай уялдуулж, ирээдүйн хүлээлтийг тооцдог арга.


[9] Улирлын дундаж инфляц

голлон нөлөөлж буй бүлгүүдийг дэлгэрүүлж тайлбарлавал:

Махнаас бусад дотоодын хүнсний үнэ 2 дугаар сард жилийн 28.4 хувиар өсөж, инфляцад үзүүлэх нөлөө 3.2 нэгж хувь буюу IV улирлаас 0.1 нэгж нэмэгдэв. Үүнд, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Тодруулбал, гурилын үнэ 2 дугаар сард жилийн 57.1 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 30.2 хувь өсөж, нийлээд инфляцын 1.4 нэгж хувийг бүрдүүлжээ.

Үйлчилгээний үнэ тайлант сард жилийн 8.8 хувиар нэмэгдэж, инфляцын 1.8 нэгж хувийг бүрдүүлэв.


Зураг 1.4 Инфляц, түүнд хүчтэй нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Импортын нийт бараа, бүтээгдэхүүний инфляцад үзүүлэх нөлөө нь тайлант сард 4.8 нэгж хувь буюу инфляцын 40 орчим хувийг бүрдүүлэв. Төгрөгийн ханш суларч байгаа хэдий ч 1) тээврийн саатал арилж зардал буурах, 2) гадаад инфляц болон шатахууны үнэ тогтворжиж байгаа зэргээс импортын барааны үнийн өсөлт саарч байна (Зураг 1.4).

Зураг 1.5 Улаанбаатар хотын жилийн инфляц бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

1.3. Төсөөллийн зөрүү

Өмнөх оны IV улирлын дундаж инфляц 14.0 хувь буюу төсөөллөөс 0.2 нэгж хувь бага байв. Тайлант улиралд хүнсний бүлгийн үнэ төсөөллийн орчимд буюу жилийн 14.5 хувь өссөн бол хүнсний бус бүлгийн үнэ төсөөллөөс 0.2 хувь бага буюу жилийн 13.8 хувиар өсөв. Тодруулбал, тээврийн зардал эрчтэй буурч, үйлчилгээний үнэ төсөөллөөс багаар өссөн нь хүнсний бус бүлгийн үнэ төсөөллөөс бага гарахад нөлөөлөв.

2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2023 оны эхний хагаст 13 хувьд хэвээр хадгалах;
- Нүүрсний экспортын хэмжээ 2023-2024 онд өмнөх төсөөллийн орчимд байх;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт орох урсгал 2023 онд 366 сая ам.доллар, 2024 онд 19 сая ам.долларoop өмнөх оноос нэмэгдэх;
- Олон улсын байгууллагуудын донор санхүүжилт 2023 онд 79 сая ам.долларoop өмнөх оноос бага, 2024 онд өмнөх оноос өөрчлөлтгүй, төсвийн дэмжлэг 2023 онд 200 сая ам.долларoop өмнөх оноос нэмэгдэх, 2024 онд 200 сая ам.долларoop өмнөх оноос бага байх;
- "2023-2024 онд Хөөт-Бичигт чиглэлийн 236 км төмөр зам баригдах"-аас өөр мега төсөл хэрэгжихгүй;
- Нийлүүлэлтийн болон хилийн хязгаарлалт байхгүй.

Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 2023 онд 4.0 хувь, 2024 онд 5.0 хувьтай байх тооцоололтой байна (Хүснэгт 2.1). Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нийлүүлэлт болон эрэлт талаас задлан тайлбарлав.

Хүснэгт 2.1 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл[10]

	2022	2023*	2024*
		төсөөлөл	
ДНБ-ий өсөлт	**4.8**	**4.0 [2.0-6.0]**	**5.0 [2.3-7.8]**
Уул уурхай	-11.9	14.7 [12.7– 16.7]	9.4 [6.7– 12.2]
Уул уурхайн бус	7.5	2.6 [0.6-4.6]	4.4 [1.7-7.2]

Эх сурвалж: Монголбанк


[10] 30 хувийн магадлалтай итгэх интервал

Нийт нийлүүлэлт

Нийт үйлдвэрлэлийн 2023 оны өсөлтийн төсөөллийг 4 хувьд хүргэж нэмэгдүүллээ (Зураг 2.1). Үүнд, хилийн хязгаарлалт суларч, экспорт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлтийн төсөөлөл сайжирсан нь голлон нөлөөлөв. Уул урхайн бус салбарын хувьд, нүүрсний экспорт сайжирч авто замын тээвэр нэмэгдэх, мөн дамжин өнгөрөх ачаа тээвэр хэвийн түвшинд хүрч сэргэснээр тээврийн салбар эрчимжих хүлээлттэй байна. Түүнчлэн, бойжсон малын тоо өндөр байгаагаас үүдэн энэ онд том малын тоо өсөхөөр байгаа нь хөдөө аж ахуйн салбарыг дэмжиж, мах бэлтгэл, ус ундаа зэрэг хүнсний үйлдвэрлэл нэмэгдэхээр байгаа нь боловсруулах салбарын өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэхэд нөлөөллөө. Харин мэдээлэл холбоо, эрчим хүчний салбарын саарах хандлага үргэлжилж, өрхийн хэрэглээний өсөлт удааширснаар худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар зэрэг салбарын өсөлт саарах төлөвтэй байна.

Ирэх онд нүүрс болон төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэнэ гэж үзсэнээр уул уурхайн салбар улмаар нийт эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс сайжрах хүлээлттэй байна.

Зураг 2.1 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Уул уурхай: БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогын хязгаарлалт сулран нүүрсний экспорт сайжирснаар нүүрсний олборлолт нэмэгдэхийн зэрэгцээ төмрийн хүдэр, газрын тос зэрэг түүхий эдийн олборлолт нэмэгдэж энэ онд уул уурхайн үйлдвэрлэл өмнөх оноос идэвхжихээр байна. Харин ирэх онд зэсийн баяжмал, баяжмал дахь алт болон зэсийн агууламж нэмэгдэх мөн төмрийн хүдэр, газрын тос, алтны үйлдвэрлэл эрчимжиж уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэхээр байна.

Уул уурхайн бус: Уул уурхайн бус салбар энэ онд 2.6 хувиар өсөж өмнөх оноос саарахаар авч үзлээ. Тодруулбал, боловсруулах болон эрчим хүчний салбарын өсөлт өмнөх оны түвшинд хадгалагдах бол хилийн хязгаарлалт суларч авто болон төмөр замын тээвэр идэвхэжсэнээр тээврийн салбар уул уурхайн бус салбарын өсөлтийг дэмжихээр байна. Харин бусад салбарын өсөлт энэ онд өмнөх оноос буурах төлөвтэй байна. Тухайлбал, өрхийн хэрэглээний өсөлт саарах хандлага нь худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар зэрэг салбарын өсөлтөд сөрөг нөлөөтэй бол энэ онд дуусах төлөвлөгөөтэй байсан барилгын томоохон төслүүд өмнөх онд хэрэгжиж дууссанаар барилгын салбарын өсөлт энэ онд буурах хандлагатай байна. Түүнчлэн, хөдөө аж ахуйн салбарын өмнөх онд хүрсэн өндөр өсөлтийг энэ онд давахад хүндрэлтэйн дээр малын зүй бус хорогдол нэмэгдэж байгаа тул уг салбарын өсөлтийн төсөөллийг сааруулаа. Ирэх онд уул уурхайн бус салбаруудын хувьд, төсвийн импульс өмнөх оноос нэмэгдэх, гадаад эрэлт сайжрах мөн уул уурхайн салбарын эерэг дам нөлөөгөөр урт хугацааны тэнцвэрт түвшин рүүгээ дөхөж өсөх таамаглалтай байна.

Нийт эрэлт

Нийт эрэлтийн 2023 оны өсөлтийн төсөөллийг 4.0 хувьд хүргэж нэмэгдүүлэв (Хүснэгт 2.2). Дотоод эрэлт талаас нийт хүүхдийн 91 хувьд сар бүр бэлнээр олгох хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээ 100,000 төгрөг хэвээр үргэлжлэх нь өрхийн хэрэглээг дэмжихээр байгаа бол материаллаг эргэлтийн хөрөнгө өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байгаа нь хөрөнгийн нийт хуримтлалыг өсгөх хандлагатай байна. Түүнчлэн зэс, алт зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж авч үзсэн нь цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж нийт эрэлтийн төсөөллийг нэмэгдүүлэхэд нөлөөлөв. Ирэх онд барааны экспорт өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байгаа нь нийт эрэлтийг тэтгэх төлөвтэй байна.

Дотоод эрэлт: Хөрөнгийн нийт хуримтлал болон өрхийн хэрэглээний өсөлт буурах нөлөөгөөр энэ онд дотоод эрэлтийн өсөлт өмнөх оноос саарах төлөвтэй байна.

Хүснэгт 2.2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, өсөлтийн бүрэлдэхүүнээр

	2022	2023*	2024*
		төсөөлөл	
ДНБ-ий өсөлт	**4.8**	**4.0**	**5.0**
Дотоод эрэлт	12.7	0.4	-3.1
Цэвэр экспорт	-7.8	3.6	8.1

Эх сурвалж: Монголбанк

Хөрөнгийн нийт хуримтлал өмнөх онд өндөр өсөлттэй байсан суурь үеийн нөлөөгөөр энэ онд өсөлт саарахаар байна. Үүнд, эдийн засгийн уналтын үед дутагдалд орсон материаллаг эргэлтийн хөрөнгө хил нээгдсэнээр эрчтэй нэмэгдэж өмнөх оны сүүлийн 2 улиралд оргилдоо хүрсэн бол цаашид хэвийн түвшинд хүрч, өсөлт буурах, санхүүгийн нөхцөл чангарснаас үүдэлтэй хувийн хөрөнгө

оруулалт, бизнесийн зээлийн өсөлт саарахаар байгаа нь голлон нөлөөлөв. Түүнчлэн өмнөх онд дэд бүтцийн томоохон хөрөнгө оруулалтууд хийгдэж дууссан, энэ онд Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замаас өөр том төслүүд хэрэгжихгүй гэж таамаглалд авсан тул хөрөнгийн нийт хуримтлал буурахаар хүлээгдэж байна.

Өрхийн хэрэглээ цар тахлаас үүдэлтэй хөл хорио цуцлагдсанаар 4 улирал дараалан эрчимтэй өссөн бол өмнөх оны 4 дүгээр улирлаас эхлэн өсөлт удаашрах хандлагатай болсон. Энэ оноос ипотекийн зээлийн эргэн төлөлт эхэлсэн, цалингийн өсөлт нэмэгдсэн ч инфляц, ялангуяа хүнсний инфляц өндөр, Ковидын үед хуримтлагдсан өндөр хадгаламжийн өсөлт саарах төлөвтэй болж, хэрэглээний зээл хугацааны болон өр, орлогын харьцааны хязгаартаа дөхсөн зэрэг нь өрхийн орлогын болон хэрэглээний өсөлтийг цаашид хязгаарлах хүлээлттэй байна.

Цэвэр экспорт: Ирэх жилүүдэд цэвэр экспорт нийт эрэлтийг тэтгэхээр байна. Тодруулбал, энэ онд зэс, нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны экспорт сайжрах, экспортын гол түүхий эдийн үнэ өсөхөөр байгаа нь экспортын өсөлтийг дэмжих бол нөгөө талдаа нефтийн бүтээгдэхүүний үнийн хөнгөлөлт, өрхийн хэрэглээ удаашрах зэрэг нь импортын өсөлтийг сааруулах нөлөө үзүүлж улмаар цэвэр экспорт өмнөх оноос сайжрах төлөвтэй байна. Ирэх онд зэсийн баяжмалын олборлолт болон баяжмал дахь алтны агууламж нэмэгдэх нь экспортод эерэг нөлөө үзүүлэхээр байна. Харин зарим түүхий эдийн үнэ энэ оноос буурах боловч харьцангуй өндөр түвшинд хадгалагдах нь экспортын орлогод эергээр нөлөөлөх мөн хувийн аялал жуулчлал нэмэгдэх нөлөөгөөр үйлчилгээний экспорт сайжрах төлөвтэй. Харин нефтийн бүтээгдэхүүний үнийн хөнгөлөлт ирэх онд үргэлжлэх, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт саарах нөлөөгөөр импортын өсөлт буурч цэвэр экспортын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх эерэг нөлөө нэмэгдэхээр байна.


Эдийн засгийн цаашдын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Дэлхийн эдийн засгийн өсөлт төсөөллөөс муудаж, аж үйлдвэрийн салбар удаашрах эрсдэл хэвээр байгаа нь эрдэс бүтээгдэхүүний эрэлт, үнийг бууруулж болзошгүй байна. Энэ нөхцөл байдал суурь төсөөллөөс муудвал манай улсын экспортын орлого буурах, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх, төсвийн орлого төлөвлөгөөнөөс дутах, цаашлаад төсвийн болон төлбөрийн тэнцлийн хос алдагдал бий болж, эдийн засгийн өсөлтийн төлөвийг муутгах эрсдэлтэй.	Өндөр	Өндөр (сөрөг)
Нүүрсний экспортын биет хэмжээ Засгийн газрын зорилтын хүрээнд өсөх, нүүрсний экспортыг биржээр дамжуулан худалдан авагч талд борлуулах арга хэмжээний нөлөөгөөр хилийн үнэ нэмэгдэх нөхцөл үүсвэл экспортын орлого нэмэгдэн төлбөрийн тэнцлийн алдагдал буурах, нүүрсний экспорт эрчимжих нөлөөгөөр уул уурхай салбар улмаар бусад салбарт эерэг дам нөлөө үүсгэн эдийн засгийн өсөлтийн төлөв нэмэгдэх боломжтой.	Бага	Дунд (эерэг)
Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, нийлүүлэлтийн сүлжээний доголдол бүрэн арилаагүй байгаа нь манай улсын гадаад эрэлтийг голлон тодорхойлогч БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.	Дунд	Дунд (сөрөг)
Олон улсад үүсээд буй геополитикийн асуудал нь дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлын гол эх сурвалж болсон хэвээр байгаа бөгөөд цаашид хэр удаан хугацаанд үргэлжлэх, хэрхэн шийдэгдэх нь тодорхой бус байна.	Дунд	Дунд (сөрөг)

2.2. Потенциал үйлдвэрлэл

Бус нутагт үүсэн геополитикийн нөхцөл байдлаас үүдэх гадаад орчны тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Хилийн хязгаарлалт суларч, өнгөрсөн оны сүүлийн хагаст уул уурхайн салбарын уналт саарч, бусад салбаруудын идэвхжил нэмэгдэн потенциал үйлдвэрлэлийн өсөлт саарах хандлага тогтворжиж байна (Зураг 2.2).

Зураг 2.2 Потенциал үйлдвэрлэлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн мэдээллийг ашиглан тооцдог олон хувьсагчийн Калман фильтер болон Үйлдвэрлэлийн функцийн аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлт тайлант улиралд ойролцоо түвшинд дунджаар 1.5 хувийн орчимд байна. Харин нэг хувьсагчийн HP фильтерийн аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлт тайлант улиралд 4 гаруй хувьд хүрч бусад 2 аргачлалтай харьцуулахад илүү өндөр өсөлтийг илэрхийлж байна. Үйлдвэрлэлийн функцийн аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлтөд хөдөлмөр, бүтээмж сөрөг нөлөөтэй байгаа бол хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр капитал хуримтлал нэмэгдэж байна.


2.3. Үйлдвэрлэлийн зөрүү

Цар тахлын улмаас 2020 оны эхнээс сөрөг түвшинд хүрээд байсан уул уурхайн бус үйлдвэрлэлийн зөрүү тайлант улиралд эерэг чиглэлд нэмэгдлээ. Харин уул уурхайн салбар уналттай хэвээр байгаа тул нийт үйлдвэрлэлийн зөрүү хараахан потенциал түвшиндээ хүрээгүй байна (Зураг 2.3).

Уул уурхайн бус салбар сүүлийн 8 улирлын турш сэргэж, 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн цар тахлын өмнөх үе болох 2019 оны түвшнийг давж өсөөд байна. Энэ нь цар тахал болон геополитикийн хүндрэл манай эдийн засагт 2-3 жилийн хугацааны алдагдал үүсгэснийг харуулж байгаа юм. Өнгөрсөн оны эхнээс өрхийн хэрэглээ сэргэж, гадаад худалдааны эргэлт нэмэгдсэн нь цэвэр татвар, үйлчилгээний салбарыг тэтгэсэн бол, цаг агаар харьцангуй сайн байсан нь хөдөө аж ахуйн салбарт эергээр нөлөөлж уул уурхайн бус салбарын эрэлтийг тэтгэв.

БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогын арга хэмжээ суларч, тээвэрлэлт сэргэсэнтэй холбоотойгоор зарим гол нэрийн түүхий эдийн олборлолт, экспорт сүүлийн улиралд эрчимжсэнээр уул уурхайн үйлдвэрлэлийн сөрөг зөрүү тайлант улиралд буурлаа.

Зураг 2.3 Үйлдвэрлэлийн зөрүү[11]



Эх сурвалж: Монголбанк

[11] GAP загварын үр дүн

2.4. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл


Эдийн засгийн 2022 оны өсөлтийг тоймлон авч үзвэл:

- Эдийн засаг 4.8 хувиар өсөж, цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшинг 1.7 хувиар давлаа;
- Оны эхнээс тээврийн саатал аажим арилж, хөдөлмөрийн зах зээл идэвхижин дотоод, гадаад эрэлт нэмэгдэв;
- Сүүлийн хагас жилийн дүнгээр үйлдвэрлэл бүх 10 дэд бүлгийн түвшинд өмнөх оны мөн үеэс өсөв;
- Өрхийн хэрэглээ, үйлчилгээний салбаруудын өсөлт удаашлах төлөв IV улиралд ажиглагдав.

Нийт эрэлт

Эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас авч үзвэл 2022 онд бодит экспорт 31.3 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 15.5 хувь, эцсийн хэрэглээ 6.9 хувиар тус тус өсжээ. Өрхийн хэрэглээ оны эхнээс сэргэж нийт эрэлтийг жилийн турш тогтвортой тэтгэсэн бол оны дундаас хилийн боомтуудын тээврийн гацаа арилж уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдэн, хувийн секторт түүхий эд материалын эргэлтийн хөрөнгө бүрдүүлэлт эрчимжив (Зураг 2.4).

Зураг 2.4 Эцсийн хэрэглээ болон экспорт нийт эрэлтийг дэмжиж байна.




Эх сурвалж: УСХ

Нийт эрэлтийн IV улирлын 7.3 хувийн өсөлтийг гол бүрэлдэхүүнээр дэлгэрүүлж авч үзвэл:

Нүүрсний экспорт 2022 онд 31.7 сая тоннд хүрсэн бөгөөд зөвхөн IV улиралд 12.7 сая тонн нүүрс экспортод гаргасан нь түүхэн дээд үзүүлэлт боллоо (Зураг 2.5). Мөн 2021 оны IV улиралтай харьцуулахад төмрийн хүдрийн баяжмалын экспортын биет хэмжээ 32 хувь, газрын тос 89 хувиар өссөн байна. Энэ нь 2021 оны сүүлийн саруудад бий болсон төмрийн хүдрийн тээвэрлэлтийн хүндрэл, газрын тосны экспорт зогссон суурь үетэй холбоотой байна.

Зураг 2.5 Нүүрсний тээвэрлэлт хэвийн үргэлжилж байна[12]



Эх сурвалж: ГЕГ

Өрхийн хэрэглээ цар тахлын өмнөх үеэс өндөр хэвээр байгаа хэдий ч өсөлт нь удаашрах төлөв ажиглагдлаа (Зураг 2.6). Өрхүүдэд олгосон ус, цахилгааны төлбөрийн хөнгөлөлт 2022 оны эхнээс шат дараатай дуусгавар болж, цар тахлын үед 50 орчим хувиар нэмэгдээд байсан иргэдийн хадгаламжийн хэмжээ нэрлэсэн дүнгээр 2019 оны түвшинд хүрч буурсан зэрэг нь эрэлтийг удаашруулж байж болзошгүй юм. Мьюн оны эхний 3 улиралтай харьцуулахад импортын хэрэглээний эрэлт буурсан байна.

[12] 2023 оны эхний 3 сарын мэдээлэл.

Зураг 2.6 Өрхийн хэрэглээний өсөлт удааширлаа.




Эх сурвалж: УСХ

Нөгөө талаас төрийн байгууллагын хэрэглээ буюу төрийн албан хаагчдын цалин, бусад хувьсах зардлын хэмжээ оны сүүлийн улиралд өндөр дүнгээр бүртгэгдэж, улирлын өсөлтөд 2.4 хувийн эерэг нөлөө үзүүлжээ.

Хөрөнгө оруулалтын орчин өнгөрсөн улирлаас тодийлон сэргээгүй бөгөөд нийт эрэлт дэхь хөрөнгийн нийт хуримтлалын оролцоо бага хэвээр байна. Хөрөнгийн нийт хуримтлал IV улиралд 1.0 хувиар өсөж, нийт эрэлтийн өсөлтийн ердөө 0.4 нэгж хувийг бүрдүүлэв. Төсвийн батлагдсан дүнтэй харьцуулахад хөрөнгө оруулалт 2022 оны эцэст 75 орчим хувийн гүйцэтгэлтэй зарцуулагдсан бөгөөд бизнесийн зээл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ IV улиралд 2021 оны мөн үеэс буурсан байна (Зураг 2.7).

Зураг 2.7 Хөрөнгө оруулалтын орчин сэргээгүй байна.




Эх сурвалж: УСХ, Монголбанк

Нийт нийлүүлэлт

Нийт нийлүүлэлт IV улиралд 7.7 хувь, жилийн дүнгээр 4.8 хувиар өслөө. Оны эхнээс өрхийн хэрэглээ сэргэж, гадаад худалдааны эргэлт нэмэгдсэн нь цэвэр татвар, үйлчилгээний салбарыг дэмжсэн бол, цаг агаар таатай байсан тул хөдөө аж ахуйн салбарт эергээр нөлөөлөв. Ийнхүү 2022 оны эдийн засгийн өсөлтөд үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар, ХАА салбар нийтдээ 5.6 нэгж хувийн нөлөөг бүрдүүлсэн байна. Түүнчлэн оны сүүлийн хагаст аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, уул уурхайн олборлолт эрчимжиж, үүнийг дагаад тээврийн салбар сэргэлээ (Зураг 2.8).

Зураг 2.8 Үйлдвэрлэлийн бүх дэд салбар өнгөрсөн оны мөн үеэс өслөө.



Эх сурвалж: УСХ

Үйлдвэрлэлийн дэд салбараар IV улирлын гүйцэтгэлийг авч үзвэл:


Оны эцсийн мал тооллогын дүнгээр жилд бойжсон төлийн тоо түүхэн дээд хэмжээнд буюу 25.4 сая толгойд хүрсэний зэрэгцээ мах бэлтгэл эрчимжсэнээр нь хөдөө аж ахуйн салбар IV улиралд 19.7 хувиар өсөж, нийт үйлдвэрлэлийн өсөлтийг 1.9 нэгж хувиар дэмжив.

Төмөр зам, орон сууцны барилгын бүтээн байгуулалт хурдацтай өсөж, 2020-2021 онуудад уналттай байсан барилгын салбар тайлант улиралд 11.5 хувиар өслөө. Тухайлбал, Зүүнбаян-Ханги мандал

чиглэлийн 227 км урт төмөр замын барилгын үндсэн ажил 2022 онд бүрэн хийгдэж дууссан бөгөөд IV улиралд орон сууцны томоохон хороолол, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил өндөр дүнтэй бүртгэгдлээ.

Нүүрс тээвэр хэвийн үргэлжилж уул уурхайн салбарын үйлдвэрлэл 0.9 хувиар өсөх (Зураг 2.9)-ийн зэрэгцээ төмөр замын ачаа тээвэр сэргэснээр тээврийн салбар 11.9 хувиар өслөө. Нүүрсний экспорттой холбоотойгоор авто замын ачаа тээврийн орлого 160 гаран хувиар өссөн байна. Мөн оны сүүлийн саруудад төмөр замын дамжин өнгөрөх ачаа тээвэр нэмэгдэж, олон улсын геополитикийн хүндрэлийн өмнөх түвшинд хүрлээ.

Зураг 2.9 Уул уурхайн үйлдвэрлэл хэвийн үргэлжилж байна.



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Цар тахлын хязгаарлалтын араас тогтвортой сэргэж байсан хувийн хэрэглээний эрэлт саарах төлөв ажиглагдаж, зочлох үйлчилгээ, худалдааны салбар, татварын орлогын өсөлт бага зэрэг удаашрав. IV улирлын байдлаар худалдааны салбарын өсөлт 1.9 хувьд хүрч өмнөх улирлуудаас буурсан бол зочлох салбарын үйлчилгээ бодит дүнгээр өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хүрсэнгүй. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын хэмжээ ам.доллар дүнгээр өнгөрсөн оны эхний 3 улиралд 25-30 хувиар өсөж байсан нь IV улиралд 5.7 хувьд хүрч буурчээ.

Харин банк санхүүгийн системд хадгаламж, зээлийн өсөлт удаан байгаа хэдий ч банкны салбарт гадаад валютын арилжааны орлого оны эцсийн мэдээллээр өссөн дүнтэй гарлаа.

3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


3.1. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн захын IV улирлын төлөвийг тоймлон авч үзвэл:

- Ажилгүйдэл, хөдөлмөр дутуу ашиглалтын нийлмэл түвшин статистик бүртгэж эхэлснээс хойших хамгийн доод түвшинд хүрч буурав;
- Бодит цалингийн жилийн өөрчлөлт сүүлийн 2 улирал дараалан эерэг гарлаа;
- Нийгмийн даатгалд даатгуулагчид үргэлжлэн өсөв;
- Цалингийн өсөлтөөс голлон шалтгаалж нэгж хөдөлмөрийн зардал нэмэгдэж байна;

Ажилгүй иргэдээс хөдөлмөр эрхлэлт рүү шилжих хандлага тайлант улиралд үргэлжлэв. Түүнчлэн, хөдөлмөрийн насны хүн амын өсөлтөд ажиллах хүчнээс гадуурх хүн амын өсөлт том нөлөөтэй байв (Зураг 3.1).

Зураг 3.1 Ажиллагчид болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам нэмэгдэж, ажилгүй иргэд буурав.




Эх сурвалж: УСХ

Харин ажиллах хүчний оролцооны түвшин тайлант улиралд 57.9 хувьд хүрч буурсан нь 2010-2022 оны дунджаас 3 нэгж хувиар

доогуур үзүүлэлт боллоо. Харин хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2022 оны сүүлийн улиралд өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар сайжрав. Түүнчлэн, хөдөлмөр дутуу ашиглалтын нийлмэл түвшин[13] 9.3 хувь, тэр дундаа ажилгүйдлийн түвшин 5.3 хувь байгаа нь статистик тооцож эхэлснээс хойших хамгийн сайн үзүүлэлт юм (Зураг 3.2).

Зураг 3.2 Хөдөлмөрийн захын үндсэн үзүүлэлтүүд




Эх сурвалж: УСХ

Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Нийт ажиллагчдын тооны жилийн өсөлт 2022 оны турш эерэг, 4-р улиралд 2.8 хувь байв. Үүнд, боловсруулах, хөдөө аж ахуй, уул уурхай, худалдаа, тээврийн салбарт ажиллагчид нэмэгдсэн бол барилга, боловсрол, төрийн удирдлагын салбарт ажиллагчид буурчээ (Зураг 3.3).

Зураг 3.3 Боловсруулах, хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид голлон нэмэгдлээ.




Эх сурвалж: УСХ

Ажил эрхлэлттэй уялдан нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо 2022 оны эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар нэмэгдээд байна. Үүний дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс албан журмаар нийгмийн даатгалд даатгуулагчдын өсөлт бүрдүүллээ.

Харин 2021 оны турш буураад байсан сайн дураар даатгуулагчдын саарах хандлага арилж, өмнөх оны түвшинд тогтвортой байв (Зураг 3.4).


Зураг 3.4 Нийгмийн даатгалд хамрагдагчид өсөж байна.



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалд даатгуулагч нийт ажил эрхлэгчид IV улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өслөө. Эдгээр ажил эрхлэгчдийг цалингийн бүлгээр авч үзвэл сард 1.3 саяас дээш цалинтай ажиллагчдын тоо хурдтай нэмэгдсэн байна (Зураг 3.5).

Зураг 3.5 Ажиллагчдын өсөлт, цалингийн бүлгээр




Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

[13] Энэ нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, боломжит ажиллах хүч болон ажилгүйдлийн түвшинг нэгтгэсэн үзүүлэлт юм.

Ажилгүйдлийн тэтгэмж

Нийгмийн даатгалын сангаас 2022 онд нийт 79.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 30.5 мянган хүнд олгоод байна. Ингэснээр тэтгэмж авч буй нэг иргэнд ногдож буй сарын дундаж ажилгүйдлийн тэтгэмж өмнөх оны мөн үеэс 19.8 хувиар нэмэгдэж, 2.6 сая төгрөгт хүрлээ (Зураг 3.6).

Зураг 3.6 Нэг хүнд ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ нэмэгдэж байна.



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар


Цалин, өрхийн орлого

Улсын дундаж болон медиан цалин тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 20 орчим хувиар нэмэгдэж, харгалзан 1’750.2 болон 1’285.3 мянган төгрөгтэй тэнцэж байна. Үүний зэрэгцээ өрхийн сарын дундаж нийт орлого өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар өсөж 1’847 мянган төгрөгт хүрчээ.

Инфляцын өсөлтөөс шалтгаалж бодит цалин 5 улирал дараалан бууралд байсан бол сүүлийн 2 улиралд нэрлэсэн цалингийн өсөлт өндөр байж, бодит цалин өмнөх оны мөн үеэс нэмэгдээд байна (Зураг 3.7).

Эдийн засгийн голлох салбаруудаас тээвэр (38%), уул уурхай (35%), мэдээлэл холбоо (25%), үл хөдлөх хөрөнгө (23%), санхүү болон даатгалын үйл ажиллагаа (23%)-ны салбарт ажиллагчдын дундаж нэрлэсэн цалин хамгийн өндөр өсөлттэй байв. Харин мэргэжлийн шинжлэх ухаан (6%), эрүүл мэнд (12%), урлаг үзвэр (14%)-ын салбарт алба хаагчдын цалин хамгийн бага хувиар өсөв.

Зураг 3.7 Бодит цалин 2 улирал дараалан жилийн өмнөх үеэс нэмэгдэв.




Эх сурвалж: УСХ

Нэгж хөдөлмөрийн зардал

Нэгж хөдөлмөрийн зардал[14] нэмэгдэх хандлага тайлант улиралд ч хадгалагдав. Энэ үзүүлэлт сүүлийн 4 улиралд дараалан өсөж байгаа бөгөөд өсөлтийн хурд эрчимжиж байна. Үүнд цалингийн өсөлт голлон нөлөөлж байна (Зураг 3.8).

Зураг 3.8 Нэгж хөдөлмөрийн дундаж зардал өсөж байна.



Эх сурвалж: УСХ

3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл

3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжиж, банкны системийн зээлийн өсөлт тогтворжлоо.


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн саруудад нэмэгдэн 2023 оны 1 дүгээр сард 11 хувьд хүрэхэд гадаад валютын цэвэр

[14] Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалин.

орох урсгал нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Тухайлбал, гадаад цэвэр актив (ГЦА)-ын мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтөд үзүүлэх нөлөө 2022 оны 9 дүгээр сард -13.5 нэгж хувь байсан бол 12 дугаар сард -4.7 нэгж хувь, энэ оны 1 дүгээр сард 3.6 нэгж хувьд хүрч нэмэгдлээ (Зураг 3.9).

Монгол улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сард гадаад зах зээл дээр арилжаалсан “Century 2” бондын зарим хэсэг болох 997[15] тэрбум төгрөгийг төв банкны валютын харилцахад байршуулсан нь нэг талаас ГЦА-ыг нэмэгдүүлэх, нөгөө талаас уг дүнгээр засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)-ыг бууруулах нөлөө үзүүллээ[16].

Зураг 3.9 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн өсөлт 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн саарах хандлагатай байсан бол 2023 оны 1 дүгээр сард тогтвортой түвшинд байж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эерэг нөлөө нь хэвээр байна (Зураг 3.9). Харин мөнгөний нийлүүлэлтийн актив талд бусад цэвэр зүйлсийн нөлөө нь голлон нөлөөлөв.

Банкны системийн эх үүсвэр талаас гадаад валютын харилцах, хадгаламж мөнгөний нийлүүлэлтийг голлон бүрдүүлсэн хэвээр байна. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтөд төгрөгийн хадгаламж -7.4 нэгж хувь, төгрөгийн харилцах 3.4 нэгж хувь, гадаад валютын харилцах 9.9 нэгж хувь, гадаад валютын хадгаламж 5.4 нэгж хувийн нөлөөг тус тус үзүүлжээ. Тодруулбал, 2022 онд банкны системийн төгрөгийн эх үүсвэр 1.8 орчим их наяд төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан бол гадаад валютын эх үүсвэр 3.4 их наяд төгрөгөөр буюу 54.4[17] хувиар өсөв.

Зураг 3.10 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал



Эх сурвалж: Монголбанк


Улмаар эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх хандлага үргэлжлэн 2023 оны 1 дүгээр сард 35.3 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 11.5 нэгж хувиар, өмнөх сараас 1.4 нэгж хувиар өссөн дүн юм. Ханшийн нөлөөг хасаж тооцвол банкны системийн эх үүсвэрийн долларжилт 29.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.8 нэгж хувиар, өмнөх сараас 1 нэгж хувиар нэмэгджээ (Зураг 3.11).

[15] Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 3.7 нэгж хувьтай тэнцүү

[16] Түүнчлэн, ЗГЦЗ буурахад 2023 оны 12 дугаар сард эргэн төлөлт нь хийгдэх МУХБ-ны Самурай бондын төлбөр 30 тэрбум иенийг (782 тэрбум төгрөг) 2022 оны 12 дугаар сард Засгийн газрын харилцахад урьдчилан байршуулсан нь мөн нөлөөллөө.

[17] Ханшийн нөлөөг хасаж тооцвол жилийн 27.7 хувиар өсөв.


Зураг 3.11 Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн улирлуудад хурдацтай саарч байсан банкны системийн зээлийн өсөлт энэ оны 1 дүгээр сард тогтворжив. Банкны системийн зээлийн үлдэгдэл 2023 оны 1 дүгээр сард 22.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.5 их наяд төгрөг буюу 7.1 хувиар өссөн байна.

Зураг 3.12 Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, салбараар




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өсөлтийг эдийн засгийн салбараар нь авч үзвэл худалдаа, үл хөдлөх салбарын болон хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлүүд нийт зээлийн өсөлтөд 9 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв. Харин уул уурхайн салбарын зээл нийт зээлийн өсөлтөд -3 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүллээ (Зураг 3.12).

Зээлийн зориулалтаар нь ангилж харвал хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл жилийн 14.1 хувиар өссөн нь нийт зээлийн өсөлтийн 3.7 нэгж хувийг, ипотекийн зээл жилийн 14.5 хувиар өссөн нь нийт зээлийн өсөлтийн 1.9 нэгж хувийг тус тус бүрдүүлэв. Харин бизнесийн зээлийн өсөлт 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн эрчимтэй саарч, 2023 оны 1 дүгээр сард 2.4 хувьд хүрсэн нь нийт зээлийн өсөлтийн 1.5 нэгж хувийг бүрдүүллээ. Валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар нэмэгдэж, гадаад валютын зээлийн үлдэгдэл 13.0 хувиар агшсанаар зээлийн долларжилт алгуур буурч байна.


Зураг 3.13 Банкны системийн нийт зээл олголт, эргэн төлөлт (Тухайн жилд өсөн нэмэгдэх)



Эх сурвалж: Монголбанк

Банкны системээс 2022 онд нийт 31.4 их наяд төгрөгийн зээл олгосон нь 2021 оноос 3.1 их наяд төгрөг буюу 10.8 хувиар өссөн байна. Зээлийн эргэн төлөлт 2022 онд нийт 29.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 5.0 их наяд төгрөг буюу 14.9 хувиар нэмэгдээд байна. Харин 2023 оны 1 дүгээр сард 2.6 их наяд орчим төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх оны мөн үеэс 200 орчим тэрбум төгрөг буюу 10.8 хувиар өслөө.

Зураг 3.14 Банкны системийн нийт зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбаруудаар




Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл, үл хөдлөх болон худалдааны салбарын зээл олголт голлон нэмэгдсэнтэй холбоотойгоор банкны системийн зээлийн үлдэгдлийн бүтэц өөрчлөгдөж байна. Тодруулбал, 2023 оны 1 дүгээр сарын байдлаар худалдааны салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх жилийн мөн үеэс 1.5 нэгж хувиар, хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн нийт зээлд эзлэх хувь 1.7 нэгж хувиар, үл хөдлөх салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь 1.1 нэгж хувиар тус тус нэмэгдсэн бол уул уурхайн салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь 3.3 нэгж хувиар буурчээ (Зураг 3.14).

Банкны системийн анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл бага зэрэг нэмэгдсэн бол чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Тодруулбал, 2023 оны 1 дүгээр сард анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 97 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1.1 их наяд төгрөгт хүрэв. Ийнхүү анхаарал хандуулах зээл жилийн 9.4 хувиар өсөхөд барилгын салбарын анхаарал хандуулах зээл 9.5 нэгж хувь, үл хөдлөх салбарын анхаарал хандуулах зээл 4.9 нэгж хувийн нөлөөтэй байсан бол боловсруулах салбарын анхаарал хандуулах зээл -16.0 нэгж хувийн бууруулах нөлөөг үзүүлэв (Зураг 3.15). Улмаар анхаарал хандуулах зээл нийт зээлийн багцын 5.1 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Зураг 3.15 Банкуудын анхаарал хандуулах зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк


Чанаргүй зээлийн үлдэгдэл 2023 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 63 тэрбум төгрөгөөр буурч 2.0 их наяд төгрөгт хүрлээ. Банкны системийн чанаргүй зээлийн үлдэгдэл 2022 оны 8 дугаар сард активын чанарын үнэлгээтэй холбоотойгоор огцом өссөнийг эс тооцвол 2022 оны турш харьцангуй тогтвортой байв (Зураг 3.16). Улмаар чанаргүй зээл 2023 оны 1 дүгээр сарын байдлаар нийт зээлийн багцын 9.1 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурсан дүн юм.

Цаашид төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотой банкны зээл олгох боломжтой төгрөгийн эх үүсвэр тодийлөн нэмэгдэхээргүй, банкууд зээлийн шалгуур болон нөхцөлөө 2022 оны сүүлийн хагаст чангаруулсан[18] нь зээлийн нийлүүлэлтийг бууруулав. Улмаар зээлийн өсөлт нам түвшинд байх, төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор мөнгөний

[18] “Банкны зээлийн төлөв” түүвэр судалгаа

нийлүүлэлтийн өсөлт төдийлөн эрчимжихээргүй байна.

Зураг 3.16 Банкуудын чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар




Эх сурвалж: Монголбанк

3.2.2. Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 12 дугаар сарын ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж 13 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Тайлант хугацаанд бодлогын хүүний өсөлттэй холбоотойгоор банк хоорондын захын хүүнүүд нэмэгдэж хүүний коридорын голчийн орчимд тогтвортой байна. Сүүлийн саруудад төгрөгийн хадгаламжийн хүү хурдацтай өсч, зээл, хадгаламжийн хүүний зөрүү буурлаа.

Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2022 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.94 нэгж хувиар өсөж 12.4 хувьд хүрэв. Үүнд овернайт зээлийн хүү 0.91 нэгж хувиар өсөж 12.65 хувьд, ТБҮЦ барьцаалсан репо хэлцлийн хүү 1.22 нэгж хувиар өсөж 12 хувьд, банк хоорондын хадгаламжийн хүү 1.15 нэгж хувиар өсөж 12.7 хувьд, ТБҮЦ-ны шууд хэлцлийн хүү 0.88 нэгж хувиар өсөж 12 хувьд хүрсэн байна (Зураг 3.17).


Зураг 3.17 БХЗ-ын хэлцлийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Энэ оны 10 дугаар сард банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 4.7 нэгж хувиар өсөж 11.4 хувьд хүрсэн бол шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү (хөнгөлөлттэй хүүтэй зээлүүдийг хасч тооцвол) 0.8 нэгж хувиар өсөж 15.12 хувьд хүрлээ. Харин хөнгөлөлттэй хүүтэй зээлийг оруулж тооцвол нийт зээлийн хүү 1.04 нэгж хувиар өссөн буюу 14.8 хувьтай байна. Улмаар зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 3.62 нэгж хувиар буурч 3.4 хувьд хүрэв (Зураг 3.18).

Зураг 3.18 Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү болон шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү нэмэгдлээ. Шинээр олгосон гадаад валютын зээлийн дундаж хүү 2022 оны 10 дугаар сард өмнөх

оны мөн үеэс 1 нэгж хувиар өсөж 9.3 хувьд хүрсэн бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өсөж 2.17 хувьд хүрснээр гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 0.25 нэгж хувиар өсөж 7.1 хувьд хүрэв (Зураг 3.18).

Хүснэгт 3.1 Шинээр олгосон зээлийн хүү (₮), зээлдэгчдээр

Хувь, %	2021.10 сар	2022.10 сар
Зээлийн хүү (хөнгөлөлттэй зээлийг оруулснаар)	13.8	14.8
Зээлийн хүү	14.3	15.1
i. Улсын байгууллага	4.7	3.6
ii. Хувийн байгууллага	14.6	15.1
Үүнд: ААН-ийн ЖДҮ	14.5	16.0
iii. Санхүүгийн байгууллага	15.6	17.1
iv. Иргэд	14.4	15.3
Үүнд: Иргэдийн ЖДҮ	12.9	15.7
Хэрэглээ, хад.барь	14.2	15.5
v. Бусад байгууллага	2.2	18.1


Эх сурвалж: Монголбанк

3.2.3. Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2022 оны эцсээр өмнөх оноос 20.9 хувиар суларч 3444.6 төгрөгтэй тэнцэж байсан боловч 2022 оны 11 дүгээр сараас ханшийн сулрах хурд бага зэрэг саарч 2023 оны 2 дугаар сарын байдлаар 3521.9 төгрөг болоод байна (Зураг 3.19).

Үүнд, хилийн хязгаарлалт суларсантай холбоотойгоор экспортын орох урсгал нэмэгдэж, гадаад валютын урсгал цэвэр дүнгээр 2022 оны 9 дүгээр сараас эхлэн эерэг болсон нь ханш сулрах дарамтыг бууруулав. Гэсэн хэдий ч АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ үргэлжлүүлэн нэмэгдүүлж, ам.долларын ханш бусад валютуудын эсрэг чангарч байгаа нь төгрөгийн ханшид сөргөөр нөлөөлж байна.


Зураг 3.19 Төгрөгийн ам. доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) энэ оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар сул тогтлоо. Үүнээс төгрөгийн ханш рублийн эсрэг хамгийн хурдтай буюу өмнөх оны мөн үеэс 69.1 хувиар[19], ам.долларын эсрэг 22.9 хувиар, юанийн эсрэг 11.7 хувиар суларсан бол еврогын эсрэг 16.4 хувиар тус тус суларсан байна (Зураг 3.20).

Зураг 3.20 Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш, нэрлэсэн үйлчилж буй ханшийн (NEER) жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн нэрлэсэн ханш суларч, гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ буурснаар

[19] Орос улс Украина улсын дайнтай холбоотой төгрөг рублийн эсрэг огцом чангарч байсан өмнөх жилийн нөлөө

бодит үйлчилж буй ханш энэ оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар сулрав (Зураг 3.21).


Зураг 3.21 Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсантай холбоотойгоор төгрөгийн харьцангуй өгөөж 2022 оны 3 сараас хойш сөрөг түвшинд хадгалагдаж байгаа хэдий ч 2022 оны 9 дүгээр сараас эхлэн нэмэгдэж тэгтэй ойрхон буюу -0.54 хувьд хүрээд байна (Зураг 3.22). Төгрөгийн харьцангуй өгөөж ийнхүү сөрөг түвшинд хадгалагдаж байгаа нь төгрөгийн хадгаламж буурах, валютын хадгаламж өсөхөд нөлөөлсэн хэвээр байна.

Зураг 3.22 Төгрөгийн харьцангуй өгөөж



Эх сурвалж: Монголбанк

3.2.4. Хөрөнгийн зах зээл

Тайлант улиралд хөрөнгийн зах зээлийн идэвхжил өмнөх улиралтай харьцуулахад сайн байв.


Орон сууцны зах зээл

Тайлант улиралд орон сууцны үнэ буурах, түрээсийн үнэ өсөх хандлага үргэлжиллээ (Зураг 3.23)[20].

Орон сууцны үнийн индекс жилийн 5.5 хувь үүнээс шинэ болон хуучин орон сууцны үнэ[21] харгалзан жилийн 6.2 хувь, 4.9 хувиар тус тус буурлаа. Харин улирлын өсөлтийг авч үзвэл тайлант улиралд нийт орон сууцны үнэ 0.2 хувиар буурав (Зураг 3.24).

Орон сууцны ипотекийн зээлийг[22] 2022 онд шинээр 13034 зээлдэгчид олгосон нь өмнөх жилээс 28.3 хувиар, нийт олгосон ипотекийн зээлийн хэмжээ 1.4 их наяд төгрөг хүрсэн нь өмнөх жилээс 7.8 хувиар буурсан дүн юм. Хэдийгээр өрхийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр тайлант улиралд жилийн 12.4 хувиар өссөн[23] боловч өрхийн бодит орлого[24] жилийн 1.5 хувиар буурав.

Зураг 3.23 Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн жилийн өсөлт




Эх сурвалж: УСХ, Тэнхлэг-Зууч

[20] 2021 оны 10 дугаар сараас хойш УСХ-ноос ОСҮИ-ийн мэдээллийг зарлаагүй.
[21] *Эх сурвалж:* Тэнхлэг зууч ХХК
[22] *Эх сурвалж: Монголбанк.* Банкны өөрийн эх үүсвэрийн болон ОСИСТТБХ-ийн эх үүсвэрийн зээл.
[23] *Эх сурвалж: УСХ*
[24] ХҮИ-р засварлав.

Орон сууцны ипотекийн зээлийг[25] 2022 онд шинээр 13034 зээлдэгчид олгосон нь өмнөх жилээс 28.3 хувиар, нийт олгосон ипотекийн зээлийн хэмжээ 1.4 их наяд төгрөг хүрсэн нь өмнөх жилээс 7.8 хувиар буурсан дүн юм. Хэдийгээр өрхийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр тайлант улиралд жилийн 12.4 хувиар өссөн[26] боловч өрхийн бодит орлого[27] жилийн 1.5 хувиар буурав.


Зураг 3.24 Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн улирлын өсөлт



Эх сурвалж: УСХ, Тэнхлэг-Зууч

Харин өрхийн нэрлэсэн орлого өсөж, үнэ буурч байгаа нөлөөгөөр үнэ-орлогын харьцаа тайлант улиралд үргэлжлэн буурлаа (Зураг 3.25).

Зураг 3.25 Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа




Эх сурвалж: УСХ, Монголбанк

Орон сууцны зах зээлийн нөхцөл байдлыг илэрхийлэх өөр нэг чухал үзүүлэлт болох орон сууцны түрээсийн үнэ жилийн[28] 9.7 хувиар, улирлын 6.5 хувиар өсөв. Өрхийн орон сууц худалдан авах чадвар сэргэхгүй байгаа нь түрээсийн орон сууцны эрэлтийг нэмэгдүүлж, түрээсийн үнийг өсгөх талтай юм. Улмаар орон сууцны үнэ, түрээсийн өсөлтийн зөрүү нэмэгдэх хандлага сүүлийн 4 улирал үргэлжиллээ (Зураг 3.23).

Тайлант улиралд орон сууцны үнэ буурч, түрээсийн үнэ өссөн нөлөөгөөр үнэ-түрээсийн харьцаа буурав. Ийнхүү үнэ-түрээсийн харьцаа 2022 оны турш буурсан нь орон сууцны үнэ хэт өсөж, хөөсрөх эрсдэл багасаж байгааг илтгэнэ (Зураг 3.25).

Зураг 3.26 Орон сууцны барилгын өртгийн индекс (БӨИ)



Эх сурвалж: УСХ

Барилгын өртгийн индекс 2022 оны 4 дүгээр улиралд жилийн 33.3 хувь, улирлын 7.3 хувиар өсөв (Зураг 3.26). Төгрөгийн ханш суларч, импортын бараа, материалын үнэ, машин механизмын түрээсийн зардал болон цалингийн зардал нэмэгдэж байгаа нь ийнхүү барилгын өртөг үргэлжлэн өсөхөд нөлөөлж байна. Тухайлбал, барилгын өртгийн жилийн өсөлтөд материалын өртөг 18.8 нэгж хувь, машин механизмын түрээсийн зардал 1.8 нэгж хувь, цалингийн


[25] *Эх сурвалж: Монголбанк.* Банкны өөрийн эх үүсвэрийн болон ОСИСТТБХ-ийн эх үүсвэрийн зээл.
[26] *Эх сурвалж: УСХ*
[27] ХҮИ-р засварлав.
[28] *Эх сурвалж:* УСХ

зардал 12.7 нэгж хувийн нөлөөг тус тус үзүүллээ.

Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн захын идэвх тайлант улиралд сэргэж эхэллээ. Тодруулбал, ТОП 20 индекс 2022 оны эхний 3 улиралд бууралд байсан бол 12 дугаар сард 36177 нэгжид хүрч, өмнөх улирлын дунджаас 5.1 хувиар өссөн боловч өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар бага байв. Харин он гарснаар 2023 оны 1 дүгээр сарын дунджаар ТОП 20 индекс 37,443 нэгжид хүрч, өмнөх сарын дунджаас 3.5 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөн 11.8 хувиар буурлаа. Зах зээлийн үнэлгээний хувьд тайлант улиралд огцом өсөж 6.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх улирлын дунджаас 40.1 хувиар, өмнөх жилийн мөн үеэс 15.2 хувиар өндөр дүн юм. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1 дүгээр сард үргэлжлэн өсөж, өмнөх сарын дунджаас 0.4 хувиар нэмэгдсэнээр түүхэн дээд хэмжээ буюу 6.91 их наяд төгрөгт хүрлээ (Зураг 3.27).

Зураг 3.27 Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд




Эх сурвалж: Монголын хөрөнгийн биржс

Үнэт цаасны арилжааны дүн 2022 онд нийтдээ 580.6 тэрбум төгрөгт хүрсэн нь хөрөнгийн зах зээлийн идэвхжил өндөр байсан 2021 онтой харьцуулахад 59 хувиар бага дүн юм. Гэсэн хэдий ч 2022 оны 4 дүгээр улиралд 252.1 тэрбум төгрөг хүрч өмнөх улирлаас 4.8 дахин нэмэгдлээ (Зураг 3.28). Нийт арилжааны бүтцийг 2022 оноор авч үзвэл 59.1 хувийг хувьцааны арилжаа, 23.1 хувийг компанийн бондын арилжаа, 17 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа бүрдүүлэв.

Компанийн бондын арилжааны хувьд 2021 онд “Эрдэнэс таван толгой” ХК-ны нийт 692 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаатай холбоотойгоор өндөр идэвхжилтэй байсан үетэй харьцуулахад 2022 онд идэвхжил муу байв.

Хөрөнгө оруулалтын сан (ХОС)-гийн арилжаа энэ оны турш нам түвшинд байсан бол хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-ны арилжаа энэ онд идэвхжиж 98.9 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант улиралд ХБҮЦ-ны арилжаа 29.2 тэрбум төгрөг хүрсэн нь өмнөх улирлаас 2.5 дахин нэмэгдсэн дүн юм.

Зураг 3.28 Нийт арилжаа, бүтцээр[29]



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Хөрөнгийн зах зээлийн идэвх 2022 оны 4 дүгээр улиралд эрчимжихэд хувьцааны

[29] Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ), Хөрөнгө оруулалтын сан (ХОС)

анхдагч зах зээлийн арилжаа нөлөөлсөн (Зураг 3.27).

Системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани болох хуулийн шаардлагын хүрээнд 2022 оны 12 дугаар сард "Голомт банк" ХК 118 тэрбум төгрөгийн хувьцааг арилжаалсан нь тайлант улиралд хийгдсэн арилжааны 47.1 хувь, 2022 онд хийгдсэн нийт арилжааны 20 орчим хувийг эзэлж байна. Улмаар хөрвөх чадварын харьцаа[30] 2022 оны 12 дугаар сард огцом нэмэгдэж 23.7 хувьд хүрэв.

Хөрөнгийн зах зээл дээр 2022 онд хувьцааны хоёрдогч зах зээлд нийт 167.56 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 27.2 хувиар буурав. Үүнд нийт 154 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56 компанийн үнэт цаасны ханш өсөж, 94 компанийн үнэт цаасны ханш буурсан байна[31]. Тайлант улиралд 38.6 тэрбум төгрөгийн арилжаа хувьцааны хоёрдогч зах зээлд хийгдсэн нь өмнөх улирлаас 2.5 дахин өндөр дүн юм.

3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Товч агуулга:

- Батлагдсан төсвийн хүрээнд тэнцвэржүүл-сэн орлого энэ онд 1.85 их наяд, төсвийн зардал 2.3 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр байна.
- 2022 онд огцом агшаад байсан газрын тосны орлого бүрдүүлэлт энэ онд экспорттой уялдан хэвийн боллоо.
- Засгийн газрын нийт өрийн (ӨҮЦ) ДНБ-д эзлэх хэмжээ энэ онд 65 хувьд хүрч нэмэгдэхээр байна.

Нэгдсэн төсөв: Урьдчилсан гүйцэтгэлээр 2022 онд тэнцвэржүүлсэн орлого тодотгосон дүнгээс 1.7 их наяд төгрөгөөр буюу 10.8 хувиар давж, зардал бүрэн зарцуулагдсанаар тэнцвэржүүлсэн тэнцэл 1.0 их наяд төгрөгийн алдагдалтай байв (Хүснэгт 3.2).

Хүснэгт 3.2 Төсвийн үндсэн үзүүлэлтүүд

Их наяд төгрөг	2022 Гүй.	2023 Бат.	2023.02 Гүй.	Бат.
Нийт орлого	**18.6**	**19.7**	**3.0**	**107.4**
Сангийн орлого	**1.4**	**0.7**	**0.2**	**15x**
Тэнцвэржүүлсэн орлого	**17.2**	**19.0**	**2.8**	**100.2**
Татварын орлого	15.6	17.2	2.6	102.2
Татварын бус орлого	1.6	1.9	0.2	79.1
Нийт зардал	**18.2**	**20.5**	**2.8**	**75.4**
Анхдагч зардал	17.4	19.3	2.5	76.1
Хүүний зардал	0.8	1.2	0.2	67.3
Нийт тэнцэл	**0.4**	**-0.8**	**0.2**	
ДНБ-д эзлэх хувь	0.9%	-1.4%	0.4%	
Тэнцвэржүүлсэн тэнцэл	**-1.0**	**-1.4**	**0.0**	
ДНБ-д эзлэх хувь	-2.1%	-2.6%	0.0%	
Анхдагч тэнцэл	**-0.2**	**-0.2**	**0.2**	
ДНБ-д эзлэх хувь	-0.3%	-0.4%	0.4%	

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн орлого төлөвлөснөөс[32] давахад ААН-ын орлогын албан татвар болон ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөрийн (АМНАТ) орлого төлөвлөснөөс өндөр байсан нь нөлөөллөө.

Энэ оны эхний 2 сард төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар өндөр төвлөрч 2.8 их наяд төгрөгт хүрсэн бол зардал 13.5 хувиар их буюу 2.8 их наяд төгрөг байв. Ийнхүү тэнцвэржүүлсэн тэнцэл 23 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ (Хүснэгт 3.2).

Тэнцвэржүүлсэн орлого 2023 онд: Эдийн засгийн идэвхжил өндөр байж, экспорт өмнөх оноос нэмэгдсэнээр батлагдсан төсвийн хүрээнд тэнцвэржүүлсэн орлого энэ онд нэрлэсэн дүнгээр 11 хувиар өсөхөөр байна. Үүнд,

- АМНАТ-ын орлого: 680 тэрбум,
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар: 610 тэрбум,


[30] Хөрвөх чадварын харьцаа $= \frac{\text{Хувьцааны нийт арилжаа}}{\text{Зах зээлийн үнэлгээ}}$;

[32] Сангийн яамны төсвийн төлөвлөгөө

[32] Сангийн яамны төсвийн төлөвлөгөө

- Нийгмийн даатгалын орлого: 570 тэрбум,
- Гаалийн албан татвар: 230 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Зураг 3.29 Төсвийн орлогын бүтэц, оны эхний 2 сард



Эх сурвалж: Сангийн яам


Оны эхний 2 сард эдийн засаг, гадаад худалдаа өнгөрсөн оноос идэвхжиж, татварын орлого 10.2 хувиар, татварын бус орлого 65.9 хувиар тус тус өсжээ (Зураг 3.29). Өмнөх оны эхний хагаст газрын тос экспортлогдоогүйгээс газрын тосны орлого тасраад байв. Харин энэ онд газрын тосны экспорт хэвийн явагдаж байгаа учир газрын тосны орлого татварын бус орлогыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

Нийт зардал, цэвэр зээл 2023 онд: Төсвийн зардал 2023 онд 2.3 их наяд төгрөгөөр буюу 13 хувиар тэлэхээр байна. Үүнээс, хөрөнгө оруулалтын зардал 1.5 их наяд, хүүний зардал 364 тэрбум, цалингийн зардал 311 тэрбум, урсгал шилжүүлэг 216 тэрбум төгрөгөөр нэмэгдэж буй бол эргэж төлөгдөх зээл 284 тэрбум төгрөгөөр буурах юм.

Энэ онд Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хуримтлалтай хүүхэд”, чанар, гүйцэтгэл, хүрэх үр дүнд чиглэсэн төсвийн санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийн ажлууд үргэлжилнэ. Иймээс татаас, шилжүүлгийн зардал өмнөх оны адил нийт зардлын тал орчим хувийг бүрдүүлэхээр байна.

Эхний 2 сарын байдлаар татаас, шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар өссөн бөгөөд хүүхдийн тэтгэмж болон ахмад настны тэтгэврийн зардал төлөвлөгөөний дагуу өссөн нь нөлөөлжээ. “Хуримтлалтай хүүхэд”, эрүүл мэнд, боловсролын салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо хэрэгжүүлж буйгаас төсвийн татаас, шилжүүлэг нийт зардлын талаас[33] илүүг бүрдүүлсэн хэвээр байна (Хүснэгт 3.2).

Зураг 3.30 Төсвийн зардлын бүтэц, оны эхний 2 сард



Эх сурвалж: Сангийн яам

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр: Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр 2022 онд 26.9 их наяд буюу нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь 51 хувь байв. Энэ оны хувьд нэрлэсэн ДНБ-ний 65.0 хувь байхаар батлагдсан нь хуулийн[34] заасан хязгаарт хүрч нэмэгдэхээр байна (Хүснэгт 3.3).

[33] 2010-2020 оны дундаж 32 хувь, 2021 онд 47 хувь, 2022 онд 53 хувь, 2023 оны эхний 2 сард 62 хувь

[34] Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2022 онд 70, 2023 онд 65, 2024 онд 60 хувиас хэтрүүлэхгүй байхаар заажээ.

Хүснэгт 3.3 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

тэрбум төгрөг	2021 Гүй.	2022* Урьд. Гүй.	2023* Бат.
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	21837	26938	35435
ДНБ-д эзлэх хувь	50.1	51.0	65.0
Өрийн хязгаар	**70.0**	**70.0**	**65.0**
Зээлийн үйлчилгээний төлбөр	828	816	1181
Төсвийн орлогод эзлэх хувь	6.5	4.7	6.2
Төсвийн тэнцэл	-2909	-979	-1426
ДНБ-д эзлэх хувь	-4.5	-1.9	-2.6


Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

4.1. Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл

Гадаад эрэлт: Дэлхийн эдийн засгийн өсөлт 2022 онд урьдчилсан гүйцэтгэлээр 3.4 хувь гарч олон улсын байгууллагуудын төсөөллийн дунджаас 0.4 нэгж хувиар өндөр байв. Харин 2023 оны өсөлтийн төсөөлөл 2.1 хувь болж өмнөх төсөөллөөс бага зэрэг муудлаа. Тодруулбал, БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын арга хэмжээ 2022 оны 12 дугаар сараас суларсан нь глобал өсөлтөд эерэг нөлөөтэй хэдий ч дэлхийн томоохон төв банкуудын мөнгөний хатуу бодлогын нөлөө хүчтэй илрэх төлөвтэй байгаа нь өсөлтөд ийнхүү сөргөөр нөлөөлөхөөр байна. Гэхдээ шинжээчдийн дүгнэлтээр ОХУ-Украины мөргөлдөөний нөхцөл байдал цаашид даамжрах, дэлхийн төв банкуудын мөнгөний хатуу бодлогын нөлөө глобал эдийн засагт 2023 онд хүчтэй илрэх нь дэлхийн эдийн засгийн төлөвт гол эрсдэл болж байна.

Зураг 4.1 Улс орнуудын өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Блүмберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр 2022 онд 3.0 хувь гарснаар 5.5 хувийн зорилтот түвшнээс доогуур байв. Энэ нь “Ковид-19” цар тахлын үеийг эс тооцвол 1976 оноос хойших хамгийн бага өсөлтийн түвшин юм. “Тэг-Ковид” бодлогын арга хэмжээ суларсантай холбоотойгоор БНХАУ-ын 2023 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг ОУВС өмнөхөөс 0.8 нэгж хувиар сайжруулан 5.2 хувьд хүргэсэн байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт энэ онд өмнөх оноос саарч гадаад эрэлт буурах, дэлхий дахинд үүсээд буй нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжлэх эрсдэл нь нөгөө талаас БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

АНУ-ын эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр 2022 онд 2.1 хувьд хүрч олон улсын шинжээчдийн төсөөллөөс[35] өндөр байв. Хэдийгээр өсөлт хүлээлтээс өндөр гарсан ч цаашид тус улсын эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй боллоо. ОУВС-гийн төсөөллөөр 2023 оны өсөлтийг 0.5 хувь болгож өмнө тооцоолж байснаас 1.9 нэгж хувиар бууруулжээ. Дэлхийн банкны

[35] Өмнөх төсөөлөлд АНУ-ын 2022 оны эдийн засгийн өсөлтийг 1.6 хувь гэж үзэж байсан.

“Глобал эдийн засгийн төлөв”, ОУВС-гийн “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлангуудад дурдсанаар ХНБ-аас бодлогын хүүг эрчтэй нэмэгдүүлсэн арга хэмжээний нөлөө эдийн засагт энэ онд хүчтэй илрэх нь өсөлтийн төсөөллийг бууруулах гол үндэслэл болж байна. Мөн EIU-ийн шинжээчид ХНБ-ны бодлогын хүү эрчтэй нэмэгдсэн нөлөөгөөр 2023 оны эхний хагаст АНУ-ын эдийн засгийн өсөлт сөрөг түвшинд хүрч, хямрал үүсэж болзошгүй байгааг анхааруулж байна.

Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2022 онд 3.5 хувьд хүрч хүлээлтээс[36] өндөр гарлаа. Тодруулбал, ОХУ-Украины нөхцөл байдлаас шалтгаалсан эрчим хүчний үнийн өсөлт аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлд сөрөг нөлөөтэй хэвээр байгаа ч аялал жуулчлалын орлого, үйлчилгээний салбарын өсөлт хүлээлтээс давсан нь Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг тэтгэв. Түүнчлэн, Европын төв банкнаас 2022 онд бодлогын хүүг хурдтай нэмэгдүүлсэн шийдвэрүүд нь 2023 оны эдийн засгийн өсөлтийг удаашруулах эрсдэлтэй байгаа тухай шинжээчид онцолжээ.

ОХУ-ын эдийн засаг 2022 онд -2.5 хувьд хүрч хүлээлтээс сайн гарсан ч цаашид тодорхой бус байдал их байна. Барууны орнууд ОХУ-ын газрын тосны үнэд дээд хязгаар тогтоосон нь экспортын орлогыг бууруулж байна. Гэхдээ БНХАУ, Энэтхэг тэргүүтэй бусад улсуудад газрын тосны экспортоо цаашид нэмэгдүүлэх эсэхээс тус улсын 2023 оны эдийн засгийн өсөлт хамаарахаар байгааг Дэлхийн банкны шинжээчид онцолжээ. ОУВС-гаас ОХУ-ын эдийн засгийн 2023 оны өсөлтийн төсөөллийг 10 дугаар сарын төсөөллөөс 2.6 нэгж хувиар сайжруулж 0.3 хувьд хүргээд байна.

Гадаад инфляц: Дэлхийн ихэнх оронд инфляцын эрч саарч байна. Тухайлбал, АНУ-д инфляц 2022 оны 6 дугаар сард 9.1 хувь буюу сүүлийн 40 орчим жилийн оргил түвшинд хүрээд байсан бол 2022 оны сүүлийн хагасаас эхлэн аажмаар саарч 2023 оны 2 дугаар сард 6 хувьд хүрлээ. Томоохон эдийн засагтай Европын холбооны орнуудад 2 дугаар сард инфляцын түвшин 8.5 хувь гарч оргил үе болох өнгөрсөн оны 10 дугаар сараас 2.1 нэгж хувиар буурав. Харин Англи улсын хувьд инфляцын түвшин өндөр түвшинд хадгалагдсан хэвээр байгаа бөгөөд 2023 оны 1 дүгээр сарын байдлаар 10.1 хувьтай байна. Олон улсын байгууллагуудын төсөөллөөр глобал инфляц 2024 оноос тогтворжих хүлээлттэй байна.

Гадаад хүү: АНУ-ын 2023 оны 2 дугаар сарын инфляцын түвшин 6 хувьд хүрч саарсан ч өндөр түвшинд хэвээр байгаа тул Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүг 3 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар 0.25 нэгж хувиар өсгөж 4.75-5.0 хувьд хүргэлээ. Мөн Англи болон Европын холбооны орнуудад инфляц өндөр түвшинд хэвээр байгаа учраас энэ оны 3 дугаар сард бодлогын хүүг тус бүр 0.5 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж 3.5 хувь, 4.0 хувьд хүргээд байна.

Худалдааны нөхцөл:

Худалдааны нөхцөлийн жилийн өөрчлөлт өмнөх төсөөллөөс сайжирсан байна (Зураг 4.2). Худалдааны нөхцлийн төлөв сайжирхад олон улсын зах зээл дэх зэс болон алтны үнэ өмнөх төсөөллөөс нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

[36] Шинжээчдийн өмнөх төсөөллөөр Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.1 хувьд хүрэх төсөөлөлтэй байв.

Зураг 4.2 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.2. Экспортын үнийн төлөв

Дэлхийн эдийн засгийн өсөлт, төв банкуудын мөнгөний бодлого, ОХУ-Украины нөхцөл байдлаас голлон хамаарахаар байна.

Зэс: Зэсийн 2023 оны үнийн төсөөлөл тонн тутамдаа 8544 ам.доллар болж өмнөх төсөөллөөс 543 ам.доллароор нэмэгдлээ. Дэлхийн зэсийн хэрэглээг голлон тодорхойлогч БНХАУ-д дотоод эрэлт нэмэгдэх хүлээлтээс шалтгаалан олон улсын зах зээлд зэсийн үнийн төсөөллийг нэмэгдүүлэх гол нөхцөл болж байна. Түүнчлэн БНХАУ-ын эрх баригчдын зүгээс санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор сүүлийн 2 жилийн турш уналтад ороод байгаа үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээ мэдэгдсэн нь зэсийн эрэлтийг тэтгэх хүлээлтийг үүсгэлээ. Мөн хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн цахилгаанаар ажиллах сүүлийн үеийн технологийг дэмжих хөрөнгө оруулалт дэлхий даяар үргэлжлэн нэмэгдэхээр байгаа нь зэсийн эрэлтийг дунд хугацаанд тэтгэхээр байна.

Алт: Алтны үнийн төсөөлөл 2023 онд унц тутамдаа 1788 ам.доллар болж өмнөх төсөөллөөс 136 ам.доллароор өсөв. Цаашид ОХУ-Украины нөхцөл байдлын улмаас глобал орчинд тодорхой бус байдал зонхилох төлөвтэй байгаа тул алтны үнийн төсөөлөл нэмэгдлээ.

Коксжих нүүрс: Гангийн үйлдвэрлэлийн гол орц болох коксжих нүүрсний эрэлт БНХАУ-ын дотоод эрэлт сэргэхтэй холбоотойгоор нэмэгдэх хандлагатай байна. Гэхдээ БНХАУ Австрали улсаас импортлох нүүрсний хэмжээнд тогтоосон хязгаарыг цуцалсан нь тус улсын нийлүүлэлтийг нэмэгдүүлж нүүрсний үнийг бууруулах хүчин зүйл болж болзошгүй байна.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн 2023 оны үнийн төсөөлөл өмнөх төсөөллөөс бага зэрэг нэмэгдэж 98 ам.доллар/тонн болов. БНХАУ-д 12 дугаар сард аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хүлээлтээс давж, “Тэг-Ковид” бодлогын арга хэмжээ суларсан, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдэх зэрэг үйл явдлууд цаашид төмрийн хүдрийн үнийг өмнөх төсөөллөөс сайжрахаар хүлээгдэж байна.

Газрын тос: Брент маркын газрын тосны 2023 оны үнийн төсөөлөл баррель тутамдаа 89 ам.доллар болж өмнөх төсөөллөөс 3 ам.доллароор буурав. БНХАУ-д хөл хорио суларч, дотоод эрэлт сэргэх хүлээлт нь газрын тосны үнийг өсгөх нөлөөтэй бол барууны орнуудын ОХУ-д тавьсан газрын тосны хориг арга хэмжээний нөлөө нийлүүлэлтийн талын тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, үнийг бууруулж болзошгүй байна. Иймээс газрын тосны цаашдын төлөв олон улсын харилцаанаас ихээхэн хамаарах төлөвтэй боллоо.


4.3. Төлбөрийн тэнцэл

Монгол улсын төлбөрийн тэнцэл урьдчилсан гүйцэтгэлээр 2022 оны IV улиралд 632 сая ам.долларын ашигтай, 2022 оны нийт дүнгээр 727 сая ам.долларын алдагдалтай гарлаа[37].

- Нүүрсний экспортын биет хэмжээ 2022 оны сүүлийн хагаст нэмэгдсэн нь экспортын орлогыг тэтгэж урсгал тэнцлийн алдагдлыг бууруулав.
- Гэхдээ хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын хурдтай өсөлт, үйлчилгээний дансны өндөр алдагдал хэвээр хадгалагдаж байна.

Гадаад валютын албан нөөц 2022 оны эцэст 3.4 тэрбум ам.долларт хүрч өмнөх улирлаас нэмэгдсэн ч гадаад валютын цэвэр нөөц төдийлөн өссөнгүй. Энэ нь гадаад секторын эрсдэл даах чадварыг үргэлжлүүлэн сайжруулах шаардлага өндөр байгааг илтгэж байна.

Зураг 4.3 Төлбөрийн тэнцлийн алдагдал 2022 онд 727 сая ам.долларт хүрэв.



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийг гол бүрэлдэхүүн хэсгүүдээр дэлгэрүүлж тайлбарлавал:

Экспортын орлого 2022 оны IV улиралд өмнөх оны мөн үеэс 27.1 хувиар, жилийн дүнгээр 2021 оноос 35.6 хувиар нэмэгдлээ. Ийнхүү өмнөх оноос нэмэгдэхэд чулуун нүүрсний экспортын орлого нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Экспортын томоохон хэсгийг бүрдүүлэгч төмрийн хүдэр, зэсийн баяжмалын орлого өмнөх оноос буурч өсөлтөд харгалзан 6 болон 2 нэгж хувийн бууруулах нөлөөг үзүүлсэн бол бусад экспорт өмнөх оны орчимд байв. Зөвхөн IV улирлыг авч үзвэл нүүрсний экспорт нийт экспортын өсөлтийн дийлэнх хэсгийг тайлбарлаж, мөнгөжөөгүй алтны экспорт өмнөх оноос хамгийн ихээр буурчээ (Хүснэгт 4.1).

Хүснэгт 4.1 Нүүрс, ноолуурын экспорт нийт экспортын өсөлтийг голлон бүрдүүлж байна

сая ам.доллар	2021 IV	2022 IV	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт экспорт	**2,848**	**3,621**	**27.1**	**27.1**
Чулуун нүүрс	1,262	1,989	57.6	25.5
Бусад нүүрс	0	76	-	2.7
Боловсруулаагүй нефть	49	101	105.4	1.8
Мах, махан бүтээгдэхүүн	3	43	-	1.4
Цайрын хүдэр, баяжмал	34	60	77.4	0.9
Жонш, лейцит, нефелинт	19	41	110.9	0.8
Мөнгөний хүдэр, баяжмал	28	38	34.0	0.3
Төмрийн хүдэр, баяжмал	104	100	-4.7	-0.2
Ноолуур, ноолууран эдлэл	102	70	-32.0	-1.1
Зэсийн хүдэр, баяжмал	593	560	-5.6	-1.2
Мөнгөжөөгүй алт	544	378	-30.6	-5.8
Бусад	109	166	52.9	2.0

Эх сурвалж: ГЕГ

Импорт 2022 оны IV улиралд 36.3 хувиар, жилийн нийлбэр дүнгээр авч үзвэл өмнөх оноос 27.1 хувиар өсөв. Ийнхүү жилийн дүнгээр өсөхөд импортын дэд бүлэг бүр нөлөөллөө. Үүнд, нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалж тус бүлгийн импорт өмнөх оноос 52 хувиар нэмэгдсэн бол нийт импортод хамгийн өндөр жин эзэлдэг хөрөнгө оруулалтын бараа бүтээгдэхүүний импорт 2022 онд жилийн 20 хувиар тэлэв.

Өмнөх жил нь 41 хувиар өсөөд байсан хэрэглээний бүтээгдэхүүний импорт 2022 онд үргэлжлэн тэлж, жилийн өсөлт 23 хувьд хүрэв. Үүнийг улирлаар задлан харвал 2022 оны эхний 3 улиралд дунджаар жилийн өмнөх үеэс 30 орчим хувиар өсөж байгаад оны сүүлийн улиралд 6 хувьд хүрч жилийн

[37] Төлбөрийн тэнцлийн дэлгэрэнгүй статистикийг stat.mongolbank.mn хаягт хандан авах боломжтой.

өсөлтийн хурд саарсан байна. Хэрэв суудлын автомашиныг хасаж тооцвол бусад төрлийн хэрэглээний бүтээгдэхүүний импорт бууралттай байв (Хүснэгт 4.2).


Хүснэгт 4.2 Импорт 2-р улиралд 29.1 хувиар өсөв.

сая ам.доллар	2021 IV	2022 IV	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт импорт	1722	2348	36.3	36.3
Хэрэглээний бүтээгдэхүүн	622	658	5.7	2.1
Түргэн эдэлгээт	374	380	1.6	0.4
Удаан эдэлгээт	248	278	11.9	1.7
Суудлын автомашин	130	169	30.1	2.3
Хөрөнгө оруулалтын бүт.н	518	900	73.8	22.2
Нефтийн бүтээгдэхүүн	393	495	25.9	5.9
Дизель	184	289	56.8	6.1
Бусад шатахуун	209	207	-1.3	-0.2
Аж үйлдвэрлэлийн орц	187	291	55.8	6.0
Бусад	0	0	100.7	0.0

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

Үйлчилгээний дансны алдагдал 2022 оны IV улиралд өмнөх оны мөн үеэс 307 сая ам.долларoор тэлж 758 сая ам.доллар, жилийн дүнгээр өмнөх жилээс 582 сая ам.долларoор нэмэгдэж 2.3 орчим тэрбум ам.долларт хүрлээ (Зураг 4.4). Нүүрсний экспорт нэмэгдэж, импортын өсөлт эрчимжсэнтэй холбоотойгоор экспорт болон импортын тээврийн зардал 2022 онд жилийн 440 орчим сая ам.долларoор өссөн нь үйлчилгээний дансны алдагдлыг нэмэгдүүлэх гол хүчин зүйлс байв.


Зураг 4.4 Үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 30 хувиар тэлэв.



Эх сурвалж: Монголбанк

Орлогын дансны алдагдал IV улиралд 618 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 116 сая ам.долларoор, 2022 онд нийт 2 тэрбум ам.долларт хүрч өмнөх жилээс 230 сая ам.долларoор сайжрав (Зураг 4.5). Үүнд уул уурхайн компаниудын дахин хөрөнгө оруулалтын гарах урсгал буурсан нь голлон нөлөөллөө.


Зураг 4.5 Орлогын дансны алдагдал буурлаа.



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл 2022 онд өмнөх жилийн адил 2.0 тэрбум ам.долларын ашигтай байв. Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалт санхүүгийн дансны гол орох урсгал бөгөөд энэ жил 1.2 тэрбум ам.доллар санхүүжилт орж ирсэн нь өмнөх оноос 800 сая ам.долларoор өндөр дүн юм.

Зураг 4.6 Санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс нэмэгдэв.



Эх сурвалж: Монголбанк

Нөгөө талаас 2022 онд багцын хөрөнгө оруулалтын гарах урсгал 350 сая

ам.долларoop нэмэгдлээ. Тухайлбал, Засгийн газрын “Чингис” бондын үлдэгдэл 136 сая ам.доллар, Мик-ын “Өүлэн” бондын үлдэгдэл 88 сая ам.долларын төлбөрүүдийг энэ онд төлж дуусгасан байна.

ҮСХ-ны тооцоогоор **Гадаад худалдааны нөхцөл** 2022 оны 12-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.0 хувиар муудсан байна. Тодруулбал, нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ 17.9 хувиар, хэрэглээний бүтээгдэхүүний импортын үнэ 9.3 хувиар өссөнөөр, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний үнэ 5.5 хувиар нэмэгдсэн нь нийт импортын үнэ 10.0 хувиар өсөх шалтгаан боллоо. Харин экспортын үнэ үүнээс багаар буюу 1.3 өссөн байна. Худалдааны нөхцөл ийнхүү сүүлийн 6 сар дараалан өмнөх оны мөн үеэс муудаад байна.

Хүснэгт 4.3 Төлбөрийн тэнцлийн таамаглал 2023 он

Төлбөрийн тэнцлийн төсөөлөлд оруулсан өөрчлөлт (2023)

Экспорт	Өмнөх төсөөллөөс сайжирсан
Биет хэмжээний төсөөлөл: Өөрчлөлтгүй **Үнийн төсөөлөл:** Нүүрс ↑, зэс ↑, алт ↑	
Импорт	**Өмнөх төсөөллөөс нэмэгдсэн**
Оюу толгойн гүний уурхайн бүтээн байгуулалтад зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ ↑ → Хөрөнгө оруулалтын импортын төсөөлөл ↑ Хэрэглээний импортын гүйцэтгэл төсөөллөөс доогуур байгаа → Хэрэглээний импортын төлбөр ↓	
Үйлчилгээ	**Өмнөх төсөөллөөс муудсан**
Импорт болон экспортын ачаа тээврийн зардал ↑ Оюу толгойн гүний уурхайн бүтээн байгуулалтад зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ ↑ → Бусад үйчилгээний зардал ↑	
ГШХО	**Өмнөх төсөөллөөс буурсан**
Оюу-Толгойн гүний уурхайн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн хэмжээ өмнөх улирлын орчимд. Үүнээс ШХО хэлбэрээр орж ирэх нь↓	
Багцын ХО	**Өмнөх төсөөллийн орчимд**
МУХБ-ны Евро бондын 50 сая ам.долларыг 1-р сард төлсөн бол үлдсэн төлбөрийг дахин санхүүжүүлэх, Самурай бондыг төлөх, Засгийн газрын Гэрэгэ бондын 450 сая ам.долларыг дахин санхүүжүүлж, үлдэгдэл төлбөрийг төлөхөөр байна.	
Бусад ХО	**Өмнөх төсөөллөөс сайжирсан**
Бусад ХО хэлбэрээр оруулж ирэх Оюу-Толгойн гүний уурхайн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн хэмжээ ↑ Засгийн газрын төсвийн дэмжлэг ↑ (өмнөх жилд орж ирэх байсан нь хугацаа хойшилсон)	

Эх сурвалж: Монголбанк

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Инфляцын өмнөх болон одоогийн төсөөлөл 7
Зураг 1.2 Үнийн өсөлтийн талаарх хандлага (чиглэлийн индекс, 3 сар) 9
Зураг 1.3 Инфляц 9
Зураг 1.4 Инфляц, түүнд хүчтэй нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 10
Зураг 1.5 Улаанбаатар хотын жилийн инфляц бүрэлдэхүүнээр 10

Зураг 2.1 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт 11
Зураг 2.2 Потенциал үйлдвэрлэлийн өсөлт 14
Зураг 2.3 Үйлдвэрлэлийн зөрүү 14
Зураг 2.4 Эцсийн хэрэглээ болон экспорт нийт эрэлтийг дэмжиж байна. 15
Зураг 2.5 Нүүрсний тээвэрлэлт хэвийн үргэлжилж байна 15
Зураг 2.6 Өрхийн хэрэглээний өсөлт удааширлаа. 16
Зураг 2.7 Хөрөнгө оруулалтын орчин сэргээгүй байна. 16
Зураг 2.8 Үйлдвэрлэлийн бүх дэд салбар өнгөрсөн оны мөн үеэс өслөө. 16
Зураг 2.9 Уул уурхайн үйлдвэрлэл хэвийн үргэлжилж байна. 17

Зураг 3.1 Ажиллагчид болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам нэмэгдэж, ажилгүй иргэд буурав. 17
Зураг 3.2 Хөдөлмөрийн захын үндсэн үзүүлэлтүүд 18
Зураг 3.3 Боловсруулах, хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид голлон нэмэгдлээ. 18
Зураг 3.4 Нийгмийн даатгалд хамрагдагчид өсөж байна. 18
Зураг 3.5 Ажиллагчдын өсөлт, цалингийн бүлгээр 18
Зураг 3.6 Нэг хүнд ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ нэмэгдэж байна. 19
Зураг 3.7 Бодит цалин 2 улирал дараалан жилийн өмнөх үеэс нэмэгдэв. 19
Зураг 3.8 Нэгж хөдөлмөрийн дундаж зардал өсөж байна. 19
Зураг 3.9 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал 20
Зураг 3.10 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал 20
Зураг 3.11 Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт 21
Зураг 3.12 Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, салбараар 21
Зураг 3.13 Банкны системийн нийт зээл олголт, эргэн төлөлт (Тухайн жилд өсөн нэмэгдэх) ..21
Зураг 3.14 Банкны системийн нийт зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбаруудаар..22
Зураг 3.15 Банкуудын анхаарал хандуулах зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар 22
Зураг 3.16 Банкуудын чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар 23
Зураг 3.17 БХЗ-ын хэлцлийн хүү 23
Зураг 3.18 Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү 23
Зураг 3.19 Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 24
Зураг 3.20 Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш, нэрлэсэн үйлчилж буй ханшийн (NEER) жилийн өөрчлөлт 24
Зураг 3.21 Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт 25
Зураг 3.22 Төгрөгийн харьцангуй өгөөж 25
Зураг 3.23 Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн жилийн өсөлт 25
Зураг 3.24 Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн улирлын өсөлт 26
Зураг 3.25 Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа 26
Зураг 3.26 Орон сууцны барилгын өртгийн индекс (БӨИ) 26
Зураг 3.27 Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд 27
Зураг 3.28 Нийт арилжаа, бүтцээр 27

Зураг 3.29 Төсвийн орлогын бүтэц, оны эхний 2 сард 29
Зураг 3.30 Төсвийн зардлын бүтэц, оны эхний 2 сард 29

Зураг 4.1 Улс орнуудын өсөлтийн төсөөлөл 30
Зураг 4.2 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт 32
Зураг 4.3 Төлбөрийн тэнцлийн алдагдал 2022 онд 727 сая ам.долларт хүрэв. 33
Зураг 4.4 Үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 30 хувиар тэлэв 34
Зураг 4.5 Орлогын дансны алдагдал буурлаа. 34
Зураг 4.6 Санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс нэмэгдэв. 34

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 Инфляцын төсөөлөл 8
Хүснэгт 1.2 Инфляцын хүлээлт 9

Хүснэгт 2.1 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 11
Хүснэгт 2.2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, өсөлтийн бүрэлдэхүүнээр 12

Хүснэгт 3.1 Шинээр олгосон зээлийн хүү (₮), зээлдэгчдээр 24
Хүснэгт 3.2 Төсвийн үндсэн үзүүлэлтүүд 28
Хүснэгт 3.3 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр 30

Хүснэгт 4.1 Нүүрс, ноолуурын экспорт нийт экспортын өсөлтийг голлон бүрдүүлж байна 33
Хүснэгт 4.2 Импорт 2-р улиралд 29.1 хувиар өсөв. 34
Хүснэгт 4.3 Төлбөрийн тэнцлийн таамаглал 2023 он 35

МОНГОЛБАНК